


УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР



**ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН
БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2021 он

АГУУЛГА		Хуудасны дугаар
НЭГ.	ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ	
	1.1. Үнэлгээ хийх үндэслэл	3
	1.2. Үнэлгээ хийх хүрээ	3
	1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт	4
	1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр	5
	1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолол	6
	1.6. Үнэлгээний мэдээлэл цуглуулсан талаар	9
ХОЁР.	ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ	
	2.1. Бирж, түүний үйл ажиллагаа	10
	2.2. Биржийн арилжаанд оролцогч	25
	2.3. Биржийн үйл ажиллагаанд хяналт тавих	30
ГУРАВ.	ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	32
	ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	
	Хүснэгт, зургийн жагсаалт	
Хүснэгт 1.	Үнэлгээний шалгуур үзүүлэлт	4
Хүснэгт 2.	Үнэлгээний шалгуур үзүүлэлтийн харьцуулах хэлбэр	5
Хүснэгт 3.	Шалгуур үзүүлэлтийн томьёолол	7-8
Хүснэгт 4.	Биржийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдал	9
Хүснэгт 5.	Статистик мэдээний харьцуулсан дүн	14
Хүснэгт 6.	Арилжааны болон бараа, түүхий эдийн тоо, мөнгөн дүн	17
Хүснэгт 7.	Биржийн 2017-2020 оны арилжааны дүн	18
Хүснэгт 8.	Итгэмжлэгдсэн этгээдийн мэдээлэл	21
Хүснэгт 9.	Нэгтгэсэн журмуудаар зохицуулж байгаа харилцаа	24
Хүснэгт 10.	Биржийн арилжаанд оролцогчдын тоон мэдээлэл	26
Хүснэгт 11.	Хураамж, суудлын төлбөрийн хэмжээ	29
Зураг 1.	Арилжааны мөнгөн дүн /тэрбум төгрөг/	18

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

1.1. Үнэлгээ хийх үндэслэл:

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3-т “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.” гэсэн зорилтыг дэвшүүлэн энэ хүрээнд мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг үүсгэн байгуулах, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжихтай холбоотой харилцааг зохицуулах зорилт бүхий “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” /цаашид “Биржийн тухай” гэх/ хуулийг Улсын Их Хурлаас 2011 оны 06 дугаар сарын 02-ны өдөр нийт 5 бүлэг, 17 зүйлтэйгээр баталсан.

Биржийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний зорилго нь хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг тодорхойлж, хууль анх батлагдан гарч байсан үеийн үзэл баримтлал, хуулийн зорилт, зорилгодоо хүрч байгаа эсэхийг судалж, цаашид хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход хувь нэмэр оруулах явдал юм.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнээс 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн УИХ-03/9581 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “...хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно.” гэснийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын Тамгын газраас уг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэлээ.

1.2. Үнэлгээ хийх хүрээ:

Биржийн тухай хуулийн хэрэгжилтийн байдалд бүхэлд нь үр дагаврын үнэлгээг хийх бөгөөд агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэхүйц **Бирж түүний үйл ажиллагаа, биржийн арилжаанд оролцогч, биржийн үйл ажиллагаанд хяналт тавих ба хариуцлага, бусад зүйл** гэсэн 4 бүлгийг сонгож үнэлгээний хүрээг тогтоосон.

Биржийн хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлох, уг хуулийн зорилго, үзэл баримтлалаар тодорхойлсон үр дүнд хүрсэн байдлыг тогтоох үүднээс хуулийн хэрэгжилтийн байдалд бүхэлд нь үр дагаврын үнэлгээ хийж, тохирох хэмжүүрийг сонгон, холбогдох мэдээллийг цуглуулан, дүн шинжилгээ хийсэн болно.

Үнэлгээ хийх хүрээг тогтоож түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, дараах алхмуудын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох;

- Шалгуур үзүүлэлтийг сонгож томъёолох;
- Харьцуулах хэлбэрийг сонгох;
- Богино хугацаанд төрөл бүрийн эх сурвалжаас мэдээлэл цуглуулах аргыг сонгож цуглуулсан.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт:

Үнэлгээний хүрээ, онцлогоос шалтгаалан хуулийн хэрэгжилтийн бодит байдлыг тодорхойлоход чиглэгдсэн дараах шалгуур үзүүлэлтийг аргачлалын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс үнэлэх зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийг бодитойгоор илэрхийлж чадах шалгуур үзүүлэлтийг энэ үе шатанд харгалзан сонгов.

Үнэлгээний үндсэн шалгуур үзүүлэлтүүдээс зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдал, хүлээн зөвшөөрөгдсөн байдал гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг үнэлгээний хамрах хүрээнд тухайн зохицуулалтын хэрэгжилтийг шалгаж чадах, тэдгээрийг хэмжих боломжтой байдлыг харгалзан сонгож авсан болно. Үүнд:

1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлт нь хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойших хугацаанд хуулийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг тогтоох замаар хууль зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэхэд тохиромжтой юм.
2. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлт нь хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг үнэлэхэд тохиромжтой юм.
3. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлт нь хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон бодит амьдрал дээр гарч буй эерэг болон сөрөг үр дагаврууд, хэрэгжилтийн явцад гарч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлж үнэлэхэд тохиромжтой юм.

Хүснэгт 1. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Д/д	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл, хэсэг	Шалгуур үзүүлэлт
1	Хоёрдугаар бүлэг. Бирж түүний үйл ажиллагаа	4 дүгээр зүйл. Бирж 5 дугаар зүйл. Биржийн чиг үүрэг 6 дугаар зүйл. Биржийн төлбөр тооцоо, хадгаламж 7 дугаар зүйл. Биржийн арилжааны төрөл, хэлбэр 8 дугаар зүйл. Биржийн зохицуулах зөвлөл 9 дүгээр зүйл. Биржийн ажилтанд хориглох зүйл	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал.
2	Гуравдугаар бүлэг. Биржийн харилцаанд оролцогч	10 дугаар зүйл. Биржийн арилжаанд оролцогч 11 дүгээр зүйл. Биржийн арилжаанд оролцогчийн эрх, үүрэг 12 дугаар зүйл. Биржийн арилжаанд оролцогчид хориглох зүйл	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал.
3	Дөрөвдүгээр бүлэг. Биржийн үйл ажиллагаанд тавих хяналт	13 дугаар зүйл. Аудит 14 дүгээр зүйл. Биржийн тайланг олон нийтэд мэдээлэх	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал.
4	Тавдугаар бүлэг. Бусад зүйл	15 дугаар зүйл. Биржийн үйл ажиллагаатай холбогдсон маргааныг шийдвэрлэх 16 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал.

Шалгуур үзүүлэлтийг сонгохдоо тухайн зүйл, хэсэг, заалтын "хэрэгжилтийг хамгийн сайнаар илэрхийлэн гаргаж ирэх" гэсэн шаардлагаар сонгосон бөгөөд тухайн хуулийн зохицуулалтад төдийлөн ач холбогдолтой бус шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр:

Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг тогтоох ажиллагаа нь практикт тухайн хуулийн үйлчлэх хүрээ, тухайн салбарт гарсан хөгжил, өөрчлөлтийг болон бусад холбогдох мэдээллийг тогтоож, тэдгээрийг хооронд нь харьцуулах ажиллагаан дээр үндэслэнэ. Өөрөөр хэлбэл, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зохицуулалтын үр дүн, үр нөлөөг зөвхөн нэг талаас үнэлэх нь учир дутагдалтай тул өмнөх үе шатанд тогтоосон шалгуур үзүүлэлт бүрд тохирсон харьцуулах хэлбэрийг сонгон үнэлгээ хийх болно.

Биржийн тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг үнэлэх шалгуур үзүүлэлтээр сонгож авсан зорилгод хүрсэн ба хэрэгжсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хууль хэрэгжүүлэх явцад бий болсон бодит үр дагавар нь анх хуулиар тавьсан зорилгоо хангаж чадаж байгааг харьцуулах аргаар тогтооно. Үүнийг харьцуулах тоо нь хуулийг хэрэгжүүлэгч чиг үүрэг бүхий байгууллагын тайлан, статистик, шүүхийн шийдвэр, судалгааны бүтээл зэрэг болно. Түүнчлэн тус хуулийн практикт хэрэгжиж буй байдлыг үнэлэхдээ хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацааг харьцуулалтын аргын тусламжтайгаар тогтоох бол хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг хууль хэрэгжиж эхэлснээс хойших тоо баримтыг байх ёстой болон одоо байгаа гэсэн харьцуулалтын аргыг ашиглан тогтооно.

Дээрх харьцуулалтын хэлбэрийн хүрээнд Биржийн хуулиар тогтоосон хөрөнгийн үнэлгээ хийх эрх зүй, зохион байгуулалтын үндэс нь өнөөгийн өөрчлөгдөн буй эдийн засаг, нийгмийн өөрчлөлт, хөгжлийн хандлагад нийцэж байгаа эсэх, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг хэрхэн зохицуулж байгаа эсэх болон уг хуулийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг судалж тогтоох юм.

Хүснэгт 2. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийн харьцуулах хэлбэр

Д/д	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл, хэсэг	Шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр
1	Хоёрдугаар бүлэг. Бирж түүний үйл ажиллагаа	4 дүгээр зүйл. Бирж 5 дугаар зүйл. Биржийн чиг үүрэг 6 дугаар зүйл. Биржийн төлбөр тооцоо, хадгаламж 7 дугаар зүйл. Биржийн арилжааны төрөл, хэлбэр 8 дугаар зүйл. Биржийн зохицуулах зөвлөл 9 дүгээр зүйл. Биржийн ажилтанд хориглох зүйл	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал.	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших
2	Гуравдугаар бүлэг. Биржийн харилцаанд оролцогч	10 дугаар зүйл. Биржийн арилжаанд оролцогч 11 дүгээр зүйл. Биржийн арилжаанд оролцогчийн эрх, үүрэг 12 дугаар зүйл. Биржийн арилжаанд оролцогчид хориглох зүйл	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал.	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших Тохиолдол судлал

3	Дөрөвдүгээр бүлэг. Биржийн үйл ажиллагаанд тавих хяналт	13 дугаар зүйл. Аудит 14 дүгээр зүйл. Биржийн тайланг олон нийтэд мэдээлэх	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал.	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших Тохиолдол судлал
4	Тавдугаар бүлэг. Бусад зүйл	15 дугаар зүйл. Биржийн үйл ажиллагаатай холбогдсон маргааныг шийдвэрлэх 16 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал. Практикт нийцэж байгаа байдал.	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших

1.5. Шалгуур үзүүлэлтийн томъёолол:

Энэ үе шатанд үнэлгээ хийх зүйл, хэсэг, заалт бүр дээр тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглал дэвшүүлж, асуулт тавих замаар шалгуур үзүүлэлтээ томъёолох юм.

Шалгуур үзүүлэлтийг томъёолох хүрээнд Биржийн тухай хуулиар зохицуулсан зүйл тус бүрийг шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавих бөгөөд таамаглал дэвшүүлэх болон асуулт тавихдаа аль болох товч, тодорхой томъёолох зарчим баримтлан ажиллалаа.

Хүснэгт 3.Шалгуур үзүүлэлтийн томъёолол

Д/д	Үнэлгээний хүрээ	Шалгуур үзүүлэлтийн зорилго	Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлтийн томъёолол
1	4 дүгээр зүйл. Бирж	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших	<ul style="list-style-type: none"> - Бирж нь биржийн арилжааг зохион байгуулахдаа бие даасан, нээлттэй, ил тод, хараат бус байх үндсэн зарчмыг хангаж ажиллаж чадаж байгаа эсэх? - Биржийн төвлөрсөн мэдээллийн сангийн бүрдүүлэлт, багтаамж, хүртээмж, ашиглалт зах зээлийн хэрэгцээ, шаардлагыг хангаж байгаа эсэх? - Цахим арилжааны тоо болон хэмнэсэн нөөц боломж бий эсэх? - Цахим арилжаа хийснээр оролцогчдын тоо нэмэгдсэн эсэх, бий болсон шинэ боломжийн талаар? - Хуульд заасан жагсаалт, журам баталсан эсэх? Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтын хэрэгжилтэд нөлөөлж буй асуудал бий эсэх? - Экспортод гаргахаар арилжаалсан бараа, түүхий эдийн тоо? - Арилжааны дүн мэдээ, шимтгэлийн хэмжээг бодитой тогтоосон эсэх? - Урамшуулал нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг биржээр арилжаалах хөшүүрэг болж чадаж байгаа эсэх? - СЗХ-ноос биржийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргээ хангалттай хэрэгжүүлж чадаж байгаа эсэх? Холбогдох журмын хэрэгжилтийн талаар?
	5 дугаар зүйл. Биржийн чиг үүрэг			<ul style="list-style-type: none"> - Хуульд тодорхойлсон “арилжаа” бодитой явагдаж чадаж байгаа эсэх? Арилжаанд оролцогчдын хуулиар олгосон эрх, үүрэг хангагдаж чадаж байгаа эсэх? - Биржийн тодорхойлолтыг үндэслэн экспортод гаргасан бараа, түүхий эдийн тоо? Биржийн тодорхойлолт нь экспортод бараа, түүхий эдийг гаргах хүчин төгөлдөр баримт бичиг болж чадаж байгаа эсэх? - Итгэмжлэл олгосон агуулах, тээврийн байгууллагын тоо, тавигдах шаардлага, хүрэлцээ, хангамжийн талаар? - Хуулиар олгосон бусад чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хүндрэл, бэрхшээлийн талаар?
	7 дугаар зүйл. Биржийн арилжааны төрөл, хэлбэр			<ul style="list-style-type: none"> - Биржийн арилжааны төрлүүд оролцогчдын хэрэгцээ, шаардлага, зах зээлийн зарчимд нийцэж байгаа эсэх? - Арилжааны төрлүүдийн хэлбэрийг сайжруулах шаардлагатай эсэх?
	8 дугаар зүйл. Биржийн зохицуулах зөвлөл			<ul style="list-style-type: none"> - Зохицуулах зөвлөл нь хуулиар олгосон чиг үүргээ хангалттай түвшинд хэрэгжүүлэн ажиллаж чадсан эсэх? - Зохицуулах зөвлөл нь хуулийн хэрэгжилтийг хангуулах болон биржийн арилжааны зах зээлд оролцогчийн үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс ямар үр дүнд гарсан? - Зохицуулах зөвлөл нь хуулийн зорилгыг хангахад дэмжлэг үзүүлсэн эсэх? - Зохицуулах зөвлөл бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хүндрэл байгаа эсэх?

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан

	9 дүгээр зүйл. Биржийн ажилтанд хориглох зүйл			<ul style="list-style-type: none"> - Биржийн ажилтанд хориглосон үйл ажиллагааг зөрчсөн талаарх тоон мэдээлэл, учруулсан хохирлын хэмжээ, авсан арга хэмжээ? - Сонирхлын зөрчлөөс сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээ зохион байгуулдаг эсэх?
2	10 дугаар зүйл. Биржийн арилжаанд оролцогч	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших Тохиолдол судлал	<ul style="list-style-type: none"> - Биржийн арилжаанд оролцогч брокер болон хоршоод арилжаанд тэнцвэртэй, тэгш, шударга оролцох боломжоор хангагдаж чадаж байгаа эсэх? - Биржийн арилжаанд оролцогчдод тулгарч буй хүндрэл, бэрхшээл? - Малчид, тариаланчид, үйлдвэрлэгчид биржийн арилжаанд шууд оролцож улмаар хуулийн зорилгыг хангахад дэмжлэг үзүүлсэн эсэх? - Хоршоо нь анхан шатны тордолт хийж стандартын шаардлага хангасан бараа, түүхий эдийг биет байдлаар нийлүүлэх гэрээ байгуулж биржийн арилжаанд оролцоно гэсэн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?
	11 дүгээр зүйл. Биржийн арилжаанд оролцогчийн эрх, үүрэг			<ul style="list-style-type: none"> - Оролцогчийн эрх, үүрэг хуулиар бүрэн зохицуулагдаж чадаж байгаа эсэх? - Мал, эмнэлгийн болон магадлан шинжилгээний гэрчилгээ нь түүхий эдийн чанарыг баталгаажуулж чадаж байгаа эсэх? - Суудлын эрхтэй байнгын гишүүн оролцогчид олгогдсон давуу эрх? - Бараа, түүхий эдийг хүлээн авах, хадгалах, бэлтгэх итгэмжлэгдсэн агуулахын тоо? - Хориглосон үйл ажиллагаа явуулсан оролцогчдод хариуцлага тооцсон талаарх мэдээлэл? - Цаашид биржийн арилжаанд оролцох эрхийг хөнддөг эсэх?
	12 дугаар зүйл. Биржийн арилжаанд оролцогчид хориглох зүйл			<ul style="list-style-type: none"> - Биржийн арилжаанд оролцогчидтой холбоотой хууль зөрчсөн тохиолдол гарч байсан эсэх болон холбогдох тоон мэдээлэл?
3	13 дугаар зүйл. Аудит	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших	<ul style="list-style-type: none"> - Үндэсний аудитын газрын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласнаар гарсан үр дүн? - Засгийн газрын хуралдаанаар дүгнэлтийг хэлэлцээд гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан эсэх?
4	15 дугаар зүйл. Биржийн үйл ажиллагаатай холбогдсон маргааныг шийдвэрлэх	Зорилгод хүрсэн байдал ба хэрэгжсэн байдал Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших	<ul style="list-style-type: none"> - Хуулийн хэрэгжилт болон биржийн үйл ажиллагаа, эрх, үүрэгтэй холбоотой асуудлаар шүүхэд гомдол, маргаан гарсан эсэх?
	16 дугаар зүйл. Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага			<ul style="list-style-type: none"> - Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээсэн этгээдийн талаарх мэдээлэл?

1.6. Үнэлгээний мэдээлэл цуглуулсан талаар:

Үр дагаврын үнэлгээний мэдээллийг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болох Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /цаашид “ХХААХҮЯ” гэх/-ны 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр ирүүлсэн албан бичиг, Хөдөө аж ахуйн биржээс хийсэн тус хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, Биржийн тухай хуулийн үзэл баримтлал зэрэг албан эх сурвалж болон “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн стратегийн төлөвлөгөө боловсруулах судалгааны ажил-Дунд шатны тайлан-2” сэдэвт судалгааны тайлан, статистик тоо баримт зэрэг эх сурвалж, холбогдох судалгаа, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэлээ.

- **Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах:** Хуулийн хэрэгжилттэй холбоотой судалгааны тайлан, статистик тоо баримт, хуулийн үзэл баримтлал зэрэг эх сурвалжийг ашигласан.
- **Холбогдох субъектүүдтэй уулзаж, мэдээлэл авах:** Хуулийн хэрэгжилтийг үр дүнтэй, бодитой гаргах, уг хуулийн харилцаанд оролцогч субъектүүдээс эрх тэгш мэдээлэл авах зорилгоор ХХААХҮЯ, Санхүүгийн Зохицуулах хороо, Хөдөө аж ахуйн бирж болон Монголын ноос ноолуурын холбоо, Монголын брокеруудын холбоо зэрэг байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт хийх, бүлгийн ярилцлага зохион байгуулах зэргээр мэдээлэл цуглуулахаас гадна бусад мэдээллийг цуглуулсан.

ХОЁР.ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

Биржийн тухай хуулийн зорилт нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг үүсгэн байгуулах, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжихтай холбоотой харилцааг зохицуулна.

Хуулийн хэрэгжилтийн хангуулах чиглэлээр хөдөө, аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 4 жагсаалт, журам, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “СЗХ” гэх/-ноос 1 журам, Бирж арилжаанд оролцогчдын нийтлэг үйл ажиллагааг зохицуулсан 14 журмыг батлуулахаар заасан бөгөөд 12 жагсаалт, журам батлагдсан байна.

Биржийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасан биржийн арилжааны зах зээлд оролцогчдын нийтлэг ажиллагааг зохицуулсан журмуудын хэрэгжилт үнэлгээний явцад олдоогүй, өнгөрсөн хугацаанд 2 удаа хуралдсан гэх мэдээлэл байх тул хэрэгжилтийн байдлыг гаргах боломжгүй болно.

Уг хууль батлагдсанаас хойш өнгөрсөн хугацаанд буюу 2013-2018 онуудад нийт 5 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд биржийн оролцогчдод хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, биржээр арилжих бүтээгдэхүүнийг мэдээллийн санд бүртгүүлэх, биржийн Зохицуулах зөвлөлийн ажлын албыг татан буулгах зэрэг өөрчлөлтүүдийг оруулсан байна.

Хүснэгт 4.Биржийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдал

Өөрчлөлт оруулсан огноо	Хуучин заалт	Өөрчлөгдсөн заалт
2013.5.24	Хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т: Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24, 25 дугаар зүйл гэснийг ... Хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт: Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.4 болон ... гэснийг	Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 42, 44, 45 дугаар зүйлд гэж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт гэж

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан

2015.11.10	Хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дах хэсэгт: Зохицуулах Зөвлөл нь ажлын албатай байна гэснийг...	Хүчингүй болгосон
2015.12.04	Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр бол эрх бүхий байцаагч зөрчлийн байдлыг харгалзан хариуцлага хүлээлгэх гэснийг...	Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж
2017.12.21	Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т: чанарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэснийг тохирлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэж
2018.11.15	Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т: Биржээр арилжих хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд гэж биржээр арилжих барааны жагсаалтад орсон, гарал үүсэл, чанарын гэрчилгээтэй, биржийн гэрээний стандартыг хангасан бараа, түүхий эдийг гэснийг 11.1.2-т: Стандартын /бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, баглаа боодлын/ дагуу бэлтгэн сумын мал эмнэлэг, үржлийн тасагт бүртгүүлж, мэргэжлийн хяналтын байцаагчийг дүгнэлт гаргуулсан бараа, түүхий эд арилжих гэснийг	Биржээр арилжих хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд гэж биржээр арилжих барааны жагсаалтад орсон, гарал үүсэл, чанарын болон мал эмнэлгийн, лабораторийн гэрчилгээтэй, биржийн гэрээний стандартыг хангасан бараа, түүхий эдийг гэж Стандартын /бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, баглаа боодлын/ дагуу бэлтгэн сум, дүүргийн хөдөө аж ахуйн мэдээллийн санд бүртгүүлж, мал эмнэлгийн болон лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээ авсан бараа, түүхий эдийг арилжих гэж

2.1.БИРЖ, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үнэлэх хэсэг	<p>4 дүгээр зүйл. Бирж</p> <p>4.2.Бирж нь биржийн арилжааг зохион байгуулахдаа бие даасан, нээлттэй, ил тод, хараат бус байх үндсэн зарчмыг баримтална.</p> <p>4.3.Бирж нь зориулалтын байр, төвлөрсөн мэдээллийн сантай байх бөгөөд биржийн арилжааг зохион байгуулах программ хангамж, сүлжээний найдвартай байдлыг хангасан байна.</p> <p>4.4.Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа биржийн арилжаанд оролцогч нь цахим сүлжээгээр дамжуулан биржийн арилжаанд шууд оролцож болно.</p> <p>4.5.Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалт, бараа, түүхий эдийг коджуулах журмыг хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>4.6.Энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортод гаргахдаа биржээр арилжаалсан байна.</p>
Томьёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> - <i>Бирж нь биржийн арилжааг зохион байгуулахдаа бие даасан, нээлттэй, ил тод, хараат бус байх үндсэн зарчмыг хангаж ажиллаж чадаж байгаа эсэх?</i> - <i>Биржийн төвлөрсөн мэдээллийн сангийн бүрдүүлэлт, багтаамж, хүртээмж, ашиглалт зах зээлийн хэрэгцээ, шаардлагыг хангаж байгаа эсэх?</i> - <i>Цахим арилжааны тоо болон хэмнэсэн нөөц боломж бий эсэх?</i> - <i>Цахим арилжаа хийснээр оролцогчдын тоо нэмэгдсэн эсэх, бий болсон шинэ боломжийн талаар?</i> - <i>Хуульд заасан жагсаалт, журам баталсан эсэх? Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтын хэрэгжилтэд нөлөөлж буй асуудал бий эсэх?</i> - <i>Экспортод гаргахаар арилжаалсан бараа, түүхий эдийн тоо?</i> - <i>Арилжааны дүн мэдээ, шимтгэлийн хэмжээг бодитой тогтоосон эсэх?</i>

Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т Бирж нь биржийн арилжааг зохион байгуулахдаа бие даасан, нээлттэй, ил тод, хараат бус байх үндсэн зарчмыг баримтална гэж заасан.

Биржийн тухай хуульд заасны дагуу биржийн арилжааг зохион байгуулахдаа бие даасан, нээлттэй, ил тод, хараат бус байх үндсэн зарчмыг баримталдаг бөгөөд эдгээр зарчмуудыг Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам, Арилжааны журам гэх зэрэг журмаар нарийвчлан зохицуулдаг байна.

Гэвч бодит байдал дээр биржээр хөдөө, орон нутгийн зах зээлээс хол малчид, хоршоодын бараа, түүхий эдийг худалдан авагч тал буюу үйлдвэрлэгч, хэрэглэгчтэй холбосон бодит арилжаа хийгддэггүй, мэдээллийн хүртээмж бага зэргээс шалтгаалан хязгаарлагдмал хүрээнд бодит бус арилжаа хийгддэгээс арилжааны мэдээлэл ил тод, нээлттэй байх гэсэн зарчим бүрэн хангагдаагүй байна.

Биржийн байнгын бус гишүүн болох хоршоодын хувьд 2018 онд 3, 2019 онд 2 хоршоо биржтэй гэрээ байгуулж, арилжаанд оролцсноос үзэхэд байнгын бус гишүүн болох хоршоо, байнгын гишүүн болох брокеруудын хооронд арилжаанд тэгш, шударга оролцох боломжоор хангагдаж чадаагүй байна.

Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3-т “Бирж нь зориулалтын байр, төвлөрсөн мэдээллийн сантай байх бөгөөд биржийн арилжааг зохион байгуулах программ хангамж, сүлжээний найдвартай байдлыг хангасан байна.” гэж заасан.

Энэ хүрээнд бирж нь 2013-2019 онд уламжлалт арилжааны системд суурилан арилжаа хийгдэж байсан бол 2020 оноос эхлэн халдлагад өртөх магадлалыг бууруулсан мэдээллийн аюулгүй байдлыг хангасан блокчейн технологид суурилсан арилжаа, төлбөр тооцооны платформыг нэвтрүүлэх зорилгоор 2.0 тэрбум төгрөгийн өртөг бүхий нийт 12 модулиас бүрдсэн программ хангамжийг нэвтрүүлэх ажлыг хийж эхэлсэн байна. Тус мэдээллийн сан нь 100,000 бичлэгт гацалтгүй, 1 секундэд 5000 гүйлгээ хийх чадвартай бөгөөд өгөгдлийн санд нийт 3,676,418 бичилт хийгдсэн ба 2013 оны 04 дүгээр сараас хойших бүх арилжааны мэдээллийг өөрийн өгөгдлийн санд хадгалж байна.

Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-т “Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа биржийн арилжаанд оролцогч нь цахим сүлжээгээр дамжуулан биржийн арилжаанд шууд оролцож болно.” гэж заасан. Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа биржийн арилжаанд оролцогч цахим сүлжээгээр дамжуулан биржийн арилжаанд шууд оролцох боломжтой. Одоо ашиглагдаж байгаа арилжаа төлбөр тооцооны систем нь үүлэн технологийг ашиглан бүтээгдсэн учир биржийн арилжаанд оролцогч интернэтэд холбогдсон тохиолдолд аль ч байршлаас /суурин болон зөөврийн компьютер, гар утас, таблет ашиглан/ биржийн арилжаанд оролцох боломж бүрдсэн байна.

Арилжаанд цахим сүлжээг ашигласнаар цаг хугацаа болон хүн хүч, зардал зэрэг бодит нөөцийг хэмнэхээс гадна хүний хүчин зүйлийн субъектив нөлөөллийг багасгах боломжийг бий болгосон байна.

Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5-д “Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалт, бараа, түүхий эдийг коджуулах журмыг хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасан.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд /цаашид “ҮХААС” гэх/-ын 2013 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн “Биржээр арилжих барааны жагсаалт, код, коджуулах журам батлах тухай” А/35 дугаар тушаалаар Хөдөө аж ахуйн биржээр арилжих “Бараа, түүхий эдийн жагсаалт, ангиллын код”-ыг баталж, тус жагсаалтад ямааны ноолуур, хонины ноосыг оруулсан.

Мөн тушаалын 2 дугаар хавсралтаар “Бараа, түүхий эдийг коджуулах журам”-ыг баталсан байна. ҮХААС-ын 2013 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/135 дугаар тушаалаар дээрх жагсаалтад хүнсний буудай, тосны ургамал /рапс/, малыг нэмж оруулан баталсан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд /цаашид “ХХААХҮС” гэх/-ын 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн “Тушаалын хавсралтад нэмэлт оруулах тухай” А-409 дүгээр тушаалаар мах, арьс ширийг биржээр арилжих жагсаалтад нэмж оруулж, өмнө батлагдсан 2013 оны А/35 дугаар тушаалын хавсралтаар баталсан бараа, түүхий эдээс ямар нэгэн бараа хасагдаагүй байна.

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд анхан шатны тордолт хийсэн, стандартын шаардлага хангасан бараа, түүхий эдийг борлуулах зохицуулалттай. Тухайлбал, ноолуурын хувьд хуулиар түүхий ноолуурыг борлуулах зохицуулалттай боловч ҮХААС-ын 2013 оны А/35 дугаар тушаалаар баталсан жагсаалтад ноолуурыг үйлдвэрлэлийн гаралтай бараа, түүхий эд буюу угаасан, самнасан ноолуурыг оруулснаараа хуулиар олгогдоогүй эрх мэдэл олгосон байна.

Угаасан, самнасан ноолуур арилжаалсан гэсэн тодорхойлолтыг олгохдоо “боловсруулаагүй” гэж угаасан ноолуурын гарцыг 70 хувиар, самнасан ноолуурын гарцыг 50 хувиар тус тус тооцож бохир ноолуур руу шилжүүлэн тооцож шимтгэл авдаг байна.

ҮХААС-ын 2013 оны А/35 дугаар тушаалаар Үйлдвэрийн бүтээгдэхүүн болох угаасан, самнасан ноолуурыг хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдэд хамааруулснаараа хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэн нийлүүлэгч, малчид нь бэлтгэсэн түүхий эдээ олон шат дамжлагагүйгээр хэрэглэгчид байнга, шууд нийлүүлэх боломжтой болно гэсэн хуулийн үзэл баримтлалд тусгагдсан нийгэм, эдийн засгийн үр дагаврыг бий болгоход чиглээгүй байна.

Түүнчлэн биржээр арилжаалах бүтээгдэхүүний жагсаалтад үйлдвэрийн бүтээгдэхүүнийг оруулсан нь боловсруулах үйлдвэрийн гаралтай бараа, түүхий эдийг арилжаалах давуу эрх олгосон, улмаар оролцогч талуудын хооронд ойлголтын зөрүү, маргаан үүсгэх нөхцөлийг бий болгосон зохицуулалт болжээ. Нөгөө талаас энэ нь малчид, малчдын хоршоод түүхий эдээ Бирж дээр гаргаж, арилжаанд оролцуулах боломжийг хязгаарласан гэж үзэж болох юм.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ын Гүйцэтгэх захирлын 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/03 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар “Хөдөө аж ахуйн биржээр арилжигдсан бараа, түүхий эдийн тодорхойлолт олгох журам”-ыг баталсан. Энэхүү журмаар биржээр арилжигдсан бараа, түүхий эдийн тодорхойлолтын маягтын болон бараа, түүхий эдийн тодорхойлолт олгохтой холбоотой үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоожээ. Арилжаалсан бүтээгдэхүүний үнийн дүнгээс бирж 1.02 хувь, брокер 0.2 хувь, Санхүүгийн зохицуулах хороо 0.08 хувь нийт 1.3 хувийн шимтгэлийг экспортод бараа, түүхий эд гаргаж байгаа аж ахуйн нэгж төлж байна.

Тохиолдол судлал: 1 контейнер ноолуур экспортод гаргахад дунджаар 55.0 сая төгрөгийг “Хөдөө аж ахуйн биржээр арилжаалсан бараа, түүхий эдийн тодорхойлолт” авахад төлж байна.

Малчид, хоршоодыг үйлдвэрлэгч, хэрэглэгчидтэй холбосон бэлтгэн нийлүүлэлт, хадгалах, тээвэрлэх, биржээр арилжихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан бодит арилжааг хийлгүйгээр зөвхөн биржээр арилжсан гэсэн тодорхойлолт авахад зориулан их хэмжээний мөнгийг төлж байгаа нь бодит байдалтай нийцээгүй, бизнес эрхлэгчдийг хаан боогдуулсан

Үйлдэл гэдгийг хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл цуглуулах шатанд төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хийсэн уулзалтын үеэр санал нэгтэй илэрхийлж байсан. Өөрөөр хэлбэл, биржээр арилжаалсан бараа, түүхий эдийн тодорхойлолтын үйлчилгээний хөлс нь бизнес эрхлэгч, үйлдвэрлэгч нарт дарамт үүсгэж, экспортыг дэмжихэд чиглээгүй байна.

Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д “Энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортод гаргахдаа биржээр арилжаалсан байна.” гэж заасан.

ҮХААС-ын 2013 оны А/35 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан Бараа, түүхий эдийн жагсаалт, ангиллын кодод тусгагдсан бараа, түүхий эдийг экспортод гаргахдаа **“биржээр арилжаалсан”** байна гэдэг хуулийн зохицуулалт бодитой хэрэгждэггүй. Зөвхөн экспортод гаргасан гэсэн тодорхойлолт авахын тулд “биржээр арилжаалсан” гэх тодорхойлолт өгдөг байна.

Өөрөөр хэлбэл, худалдагч, худалдагч талын хооронд зуучлах брокерын үйлчилгээ үзүүлдэггүй, “арилжаа” гэдэг нэрийн дор брокерууд экспортлогч, үйлдвэрлэгчдийг малчдаас түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авсны дараа бирж дээр арилжаа нөхөж хийж, бүртгэлжүүлдэг процесс явагдаж байна.

2020 оны байдлаар ноолуурын нөөцийн 58.5 хувийг, хонины ноосны 14.4 хувийг, тэмээний ноосны 59.1 хувийг Хөдөө аж ахуйн биржээр тус тус арилжаалсан байна. Нийт арилжааны дүнгийн 95.0 хувийг ноолуур, ямааны завод ноос эзэлж байна.¹

Биржийн арилжааны тодорхойлолт нь гаалийн бүрдүүлэлтэд шаардагдах баримт бичиг байх ёстойг тодорхойлсон боловч Гаалийн тухай хуульд Бараа мэдүүлэхэд шаардагдах бусад баримт бичгийг тодорхойлохдоо 60 дугаар зүйлийн 60.3.5-д “Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу эрх бүхий этгээд шаардсан тохиолдолд гарал үүслийг нотлох баримт бичиг” гэж заасан. Гаалийн тухай хуулийн энэ зохицуулалтаар Хөдөө аж ахуйн биржийн тодорхойлолтыг шаардахгүйгээр танхимаас олгож буй гарал үүслийн бичгийг үндэслэн хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг экспортод гаргадаг.

Энэ нь Гаалийн тухай хууль болон Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль хоорондын зөрчлөөс шалтгаалан биржээр арилжаалагдсан бараа, түүхий эдийн тоо, экспортод гаргасан бараа, түүхий эдийн статистик тоо мэдээлэл хоорондоо зөрүүтэй гардаг байна. Биржээр арилжаагүй бараа, түүхий эд экспортод гарах, биржийн тодорхойлолт шаардахгүйгээр гаалийн бүрдүүлэлт хийх тохиолдлууд удаа дараа гарч байгаа тул хуулийн хэрэгжилтийг хангах талаар Бирж өөрөө болон харьяа ямаар дамжуулан Гаалийн байгууллагатай харилцсан ч тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Хууль хоорондын зөрчлөөс шалтгаалан жагсаалтад орсон бараа, түүхий эд биржийн арилжаанд оролгүйгээр экспортод гарч байгаа нь Үндэсний статистикийн хорооны мэдээлэл, гаалийн статистик мэдээлэл, биржээр арилжаалагдаж байгаа бараа, түүхий эдийн тооны зөрүүтэй байдлаас харагдаж байна. Тухайлбал, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл гаалиар гарсан бараа, түүхий эд болон Хөдөө аж ахуйн биржээр арилжаанд орсон бараа түүхий эдийн зөрүү:

- Угаасан ноолуур 1,876,239 кг
- Хонины угаасан ноос 3,724,154 кг
- Тосны ургамал /рапс/ 8,123,028 кг байна².

¹ Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн стратегийн төлөвлөгөө боловсруулах судалгааны ажил – Дунд шатны тайлан-2, ХХААХҮЯ, 2021.

² Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, ХААБ, 2021.

Хөдөө аж ахуйн бирж болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хууль хоорондын зөрчлийг арилгах, уялдааг хангах зорилгоор Сангийн яам, Гаалийн Ерөнхий газар зэрэг холбогдох байгууллагуудад албан бичгээр хандахаас гадна талуудын хооронд уулзалт зохион байгуулсан хэдий ч тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Хүснэгт 5. Статистикийн мэдээний харьцуулсан дүн³

	Статистикийн мэдээ			Гаалийн Ерөнхий газар			Бирж		
	2018	2019	2020	2018	2019	2020	2018	2019	2020
Хонины самнаагүй ноос (тн)	12,189.3	14,757.7	8,510.4	12,189.3	12,189.3	8,510.4	13794.4	6686.7	5116.0
Бохир ноолуур (тн)	5,286.6	5,688.7	6,339.8	5,286.6	5,688.7	6,339.8	5862.0	5833.4	6944.1
Самнасан ноолуур (тн)	630.2	507.2	260.0	630.2	507.2	260.0			
Тэмээний угаасан эр ноос				419.4	310.1	12.0	274.0	131.9	1316.0
Тэмээний угаасан эм ноос				310.2	740.7	824.7			
Арьс шир	2018 оны байдлаар улсын хэмжээнд 17,361,500 ¹ /Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2018-д 18.2 сая.ш/ ширхэг арьс шир бэлтгэсэн. Үүнээс дотоодын хэрэгцээнд 5,207,700 ² ширхэг арьс ширийг хагас болон гүн боловсруулсан. Мөн оны байдлаар 5,288,216 ширхэг арьс шир экспортод гаргасан байна.								

Эх сурвалж: www.ubstat.mn, www.mofa.gov.mn, www.mce.mn

Үнэлэх хэсэг	4 дүгээр зүйл. Бирж 4.7.Бараа, түүхий эдийг биржийн арилжаанд оролцож худалдан авсан тухай тодорхойлолтыг үндэслэн дор дурдсан иргэн, хуулийн этгээдэд урамшуулал олгох журмыг хөдөө аж ахуй, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална: 4.7.1.хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршоо /цаашид “хоршоо” гэх/-ны гишүүн; 4.7.2.газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	- Урамшуулал нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг биржээр арилжаалах хөшүүрэг болж чадаж байгаа эсэх?

Хууль батлагдсанаас хойш хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг **биржээр арилжсан тохиолдолд** урамшуулал олгохтой холбоотой журам батлаагүй ба харин үндэсний боловсруулах үйлдвэрт ноос, сүү, арьс шир бэлтгэн тушаасан малчдад мөнгөн урамшуулал олгох, тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журмын зохицуулалтаар урамшуулал олгох тогтолцоо үйлчилж байна.

Түүнчлэн Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуульд хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршоо, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид биржийн арилжаанд оролцох хуулийн зохицуулалт байдаггүй нь тус хуулийн зохицуулалт нь хоорондоо агуулгын хувьд зөрчилтэй болохыг харуулж байна.

³Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, ХААБ, 2021 он.

Үндэсний боловсруулах үйлдвэрт ноос, сүү, арьс шир бэлтгэн тушаасан болон тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд олгох мөнгөн урамшууллыг дараах журмуудын дагуу олгож байна. Үүнд:

- *Арьс ширний урамшууллыг* Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоолоор баталсан “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”;
- *Сүүний урамшууллыг* Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор баталсан “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журам”;
- *Хонь, тэмээний ноосны урамшууллыг* Засгийн газрын 2019 оны 343 дугаар тогтоолоор баталсан “Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”;
- *Улаанбуудайн урамшууллыг* 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 290/А-504 дугаар бүхий тушаалаар баталсан “Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам”- ын дагуу тус тус олгодог байна.

Малчид, хоршоодод олгодог мөнгөн урамшууллын хэмжээ бодит бус байдаг шүүмжлэл дагуулдаг бөгөөд урамшууллыг бодитой олгох үндсэн хөшүүрэг нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг биржийн арилжаанд оруулах замаар бүтээгдэхүүний хэмжээнд үндэслэн мөнгөн урамшууллыг олгох гэж төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын үеэр дурдсан.

Үнэлэх хэсэг	4 дүгээр зүйл. Бирж 4.9.Биржийн арилжаанд оролцох тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон биржийн үйл ажиллагаанд хяналт тавих журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	- СЗХ-ноос биржийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргээ хангалттай хэрэгжүүлж чадаж байгаа эсэх? Холбогдох журмын хэрэгжилтийн талаар?

Санхүүгийн зохицуулах хорооноос Биржийн болон биржийн байнгын гишүүн брокерын үйл ажиллагаатай холбоотой дараах журмуудыг баталсан байна. Үүнд:

1. 2013 оны 69 дүгээр тогтоолоор “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”;
2. 2013 оны 264 дүгээр тогтоолоор “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн түр журам”;
3. 2014 оны 149 дүгээр тогтоолоор “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”;
4. 2014 оны 251 дүгээр тогтоолоор “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”;
5. 2019 оны 211 дүгээр тогтоолоор “Үнэт цаасны зах зээл дэх зохицуулалттай этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-г шинэчлэн тогтооход хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаанаас СЗХ-д төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг арилжаа хийсэн үнийн дүнгээс 0.04 хувь болгож 2 дахин бууруулсан.

Биржийн үйл ажиллагаанд тавих хяналтыг СЗХ хийхээр хуульчлагдсан боловч бирж нь СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхлэх эсэх асуудал зохицуулалтгүй орхигдсон байна. СЗХ-ны 2017 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай" 171 дүгээр тогтоолоор биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон.

Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн "Төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдийг тогтоох тухай" 47 дугаар тогтоолоор Биржийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж байхаар тогтоосон байна.

Биржийн шимтгэл, хураамжийн орлогын талаар: Хөдөө аж ахуйн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 08 дугаар захирамжаар биржийн байнгын болон байнгын бус оролцогчдын гишүүний хураамж, суудлын төлбөр болон арилжааны шимтгэлийг баталсан бөгөөд Хөдөө аж ахуйн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 05 дугаар захирамжаар шинэчлэн баталсан байна.

Арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаанаас СЗХ-д төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг арилжаа хийсэн үнийн дүнгийн 0.04 хувь байхаар тогтоосон бөгөөд 2022 онд 2.7 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр тусгасан байна.

2015 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар нөхцөл, шаардлагыг хангасан нийт 37 биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байдаг. Хорооноос баталсан журмыг зөрчсөн нэр бүхий 27 биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож өнөөдрийн байдлаар СЗХ-нд бүртгэлтэй 6 бирж байна.

Брокеруудын тоо ийнхүү буурсан шалтгааныг Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн стратегийн төлөвлөгөө боловсруулах судалгааны ажил /Дунд шатны тайлан-2/-д СЗХ-оос брокеруудад тавих санхүүгийн шаардлага өндөр байдгаас шалтгаалан цөөн тооны брокерууд арилжаанд оролцож, үнэ тогтоох хандлагатай байгаа талаар дурдсан байна.

Харин СЗХ-ны зүгээс санхүүгийн зах зээлд оролцогчдод тавигдах шаардлага хэт өндөр биш бөгөөд 2013 оны 69 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар Хөдөө аж ахуйн биржийн мөнгөн хөрөнгөөр бүрдүүлэх хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 200.0 сая төгрөг байхаар тогтоосон нь өнөөдрийг хүртэл хэвээр байгаа бөгөөд брокеруудын тоо буурахад нөлөөлсөн үндсэн шалтгаан болж чадахгүй гэдгийг тайлбарласан болно.

Нөгөө талаас СЗХ брокерийн үйл ажиллагаанаас үүсэх шимтгэлийн хэмжээнд тохирсон зохицуулах, хянах чиг үүргээ хангалттай хэрэгжүүлдэггүй, оролцоо муу, брокеруудад үзүүлэх үйлчилгээ хангалтгүй байгаа зэргээс шалтгаалан зарим брокерын компаниуд зохицуулалтын үйлчилгээний хөлсөө сүүлийн 2-3 жил төлөөгүй байна.

Бирж дээр ямар ч арилжаа бодитоор явагдахгүй байгааг СЗХ олон жил мэдсээр байж шимтгэл авч байгаа нь төрийн байгууллагын чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэж байна. Түүнчлэн брокеруудын зүгээс төлсөн шимтгэлийн хэмжээнд тохирсон үйлчилгээ авахгүй байгаа тул зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тусгай зөвшөөрлийн хураамж хэлбэрээр төлөх нь зүйтэй гэсэн байр суурийг илэрхийлж байна.

СЗХ-ноос "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-д хяналт шалгалт хийх ажлын хүрээнд 2015-2018 онуудад 3 удаагийн хяналт шалгалтын ажлыг хийж, зөрчил дутагдлыг илрүүлэн ажилласан байна.

Мөн Зөрчлийн тухай хуулийн 13.6-д “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль зөрчих” гэж заасан. СЗХ-ноос “Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортлохдоо биржээр арилжсан байх” гэсэн хуулийн шаардлагыг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 13.6 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн хариуцлага хүлээлгэх зохицуулалттай.

Үнэлэх хэсэг	<p>5 дугаар зүйл. Биржийн чиг үүрэг</p> <p>5.1.Бирж нь дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.1.1.биржийн арилжааг зохион байгуулах;</p> <p>5.1.4.энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортод гаргах тохиолдолд биржээр арилжсан тухай тодорхойлолтыг Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хуульд⁴ заасан экспортын барааны гарал үүслийг гэрчлэх эрх бүхий байгууллагад хүргүүлэх;</p> <p>5.1.5.биржийн арилжаанд оролцогчийг сургах, мэргэшүүлэх, итгэмжлэл олгох;</p> <p>5.1.7.энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсноос бусад нэр төрлийн бараа, түүхий эдийг биржээр арилжих жагсаалтыг батлах;</p> <p>5.1.8.биржийн арилжаанд оролцогчийн хүсэлтээр бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг хянан баталгаажуулж магадлагаа гаргах;</p> <p>5.1.9.биржийн арилжааны явцад зохиомлоор үнэ өсгөх, бууруулах оролдлого хийж байгаа эсэхэд хяналт тавих, таслан зогсоох;</p> <p>5.1.10.нэг хэлцлээр арилжих бараа, түүхий эдийн доод хэмжээг тогтоох;</p> <p>5.1.11.стандартын шаардлага хангасан агуулах, тээврийн байгууллага, лабораторит итгэмжлэл олгох.</p>
Томьёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> - Хуульд тодорхойлсон “арилжаа” бодитой явагдаж чадаж байгаа эсэх? Арилжаанд оролцогчдын хуулиар олгосон эрх, үүрэг хангагдаж чадаж байгаа эсэх? - Биржийн тодорхойлолтыг үндэслэн экспортод гаргасан бараа, түүхий эдийн тоо? Биржийн тодорхойлолт нь экспортод бараа, түүхий эдийг гаргах хүчин төгөлдөр баримт бичиг болж чадаж байгаа эсэх? - Итгэмжлэл олгосон агуулах, тээврийн байгууллагын тоо, тавигдах шаардлага, хүрэлцээ, хангамжийн талаар? - Хуулиар олгосон бусад чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хүндрэл, бэрхшээлийн талаар?


Хуулийн 5 дугаар зүйлд биржийн хэрэгжүүлэх нийтлэг 11 чиг үүргийг тодорхойлсон. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-т “биржийн арилжааг зохион байгуулах” гэж заасныг хэрэгжүүлэн 2013-2020 оны хугацаанд 1465 удаагийн арилжаа хийж, 2013 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 25-ныг хүртэлх хугацаанд 4.3 их наяд төгрөгийн нийт дүнтэй арилжаа хийсэн байна. Өөрөөр хэлбэл, жилд дунджаар 528 тэрбум төгрөгийн арилжаа хийжээ.⁵

Хүснэгт 6.Арилжааны болон бараа, түүхий эдийн тоо, мөнгөн дүн

Арилжааны тоо	1465
Борлуулагдсан бараа, түүхий эдийн тоо	9,462,022 богц
Мөнгөн дүн	5,513,420,509,175 ₮ /5.5 их наяд/

⁵ Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн стратегийн төлөвлөгөө боловсруулах судалгааны ажил – Дунд шатны тайлан-2, ХХААХҮЯ, 2021 он.

Зураг 1. Арилжааны мөнгөн дүн /тэрбум төгрөг/



2020 онд 165 удаагийн спот арилжаа зохион байгуулж, 1,377 хэлцлээр 6,944.1 тонн ноолуур, 516.2 тонн хонины ноос, 1,737.0 тонн тэмээний ноос, 3,360.0 тонн ямааны завод ноос, 509.0 тонн хонины завод ноос, 11.3 тонн тэмээний завод ноос, 3,360.0 тонн тосны ургамал /рапс/ тус тус арилжсан. 2021 оны эхний хагас жилийн байдлаар **96** удаагийн спот арилжаа зохион байгуулж **837** хэлцлээр 4,583.3 тонн ноолуур, 4,446.4 тонн хонины ноос, 360.3 тонн тэмээний ноос, 2,323.5 тонн ямааны завод ноос, 800.0 тонн тосны ургамал /рапс/, 51.2 тонн хонины завод ноос тус тус арилжсан байна.

Хүснэгт 7. 2017-2020 оны Биржийн арилжааны дүн

Он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Гэрээний төрөл /тоогоор/	Спот - 163 Форвард - 1	Спот - 157 Форвард - 1	184	Спот - 165
Нийт ноолуур /тонн/	6,955.7	5,862.0	5,851.0	6,944.1
Хонины ноос /тонн/	10,887.6	13,794.4	7,282.0	5,116.6
Тэмээний ноос /тонн/	355.5	274.0	135.0	1,316.0
Ямааны завод ноос /тонн/	1,674.1	3,262.9	1,599.0	1,736.0
Хонины завод ноос /тонн/	1,206.7	1,358.6	-	509.0
Очёс /тонн/	4.7	-	-	-
Сарлагийн хөөвөр	0.1	20.0	-	-
Адууны шир /ширхэг/	-	-	644,390	-
Тосны ургамал /тонн/	-	-	-	3,360.0
Нийт арилжааны мөнгөн дүн /тэрбум төгрөг/	572.0	711.4	706.13	488.7

Тус хуулиар биржийн арилжаа гэдэг нь биржийн арилжаанд оролцогчдын хооронд байгуулах гэрээний үндсэн дээр бараа, түүхий эдийг худалдах, худалдан авах үйл ажиллагааг хэлнэ гэж тодорхойлсон байдаг.

Гэтэл тус арилжаа бодитой бус явагддаг гэж оролцогчид үздэг. Өөрөөр хэлбэл “арилжаа” гэдэг нэрийн дор брокерууд экспортлогч үйлдвэрлэгчдийг малчдаас түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авсны дараа экспортын тодорхойлолт авахын тулд бирж дээр арилжаа хийж, бүртгэлжүүлдэг процесс явагдаж байна.

Арилжааг тухайн цаг үед нь биш түүхий эд худалдан авсны дараа нөхөж хийж байгаа нь арилжааг бодит бус, хэлбэрийн төдий явагддаг гэдгийг дахин гэрчилж байна. Үйлдвэрлэгчдийн худалдан авагч талтай хийсэн гэрээ хэлцлийг үндэслэн биржийн арилжааны гэрээ болгож бичиг баримт бүрдүүлж, шимтгэл төлж, бодит бус хуурамч арилжааг хийж үйлдвэрлэгч, экспортлогчдыг хохироож байгаа талаар төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагад оролцогчид онцолсон.

Мөн арилжаа бодитой явагддаггүй гэдэг нь арилжаанд оролцогчид хуульд тодорхойлсон оролцогч субъект буюу биржид бараа, түүхий эд арилжих зорилгоор бүртгүүлсэн, биржийн арилжаанд оролцох зөвшөөрөлтэй хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршоо биш харин бараа, түүхий эд үйлдвэрлэгч, экспортлогч нар байгаа нь арилжаа нь хуульд тодорхойлсны дагуу бодитой явагдаж чадахгүй байгааг илтгэж байна.

- Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортод гаргах тохиолдолд биржээр арилжсан тухай тодорхойлолтыг Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд заасан экспортын барааны гарал үүслийг гэрчлэх эрх бүхий байгууллагад хүргүүлэх”-ийг гэж тусгасан.

Энэ чиг үүргийн дагуу бирж нь 2013-2020 оны байдлаар нийт 8 төрлийн, 4,883,368,105,504₮ /4.9 их наяд/ төгрөгийн экспортод гаргах бараа, түүхий эдийг биржээр арилжсан тухай тодорхойлолт олгосон байна.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан бараа нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржээр арилжих бараа бол түүний гарал үүслийг биржийн тодорхойлолтыг үндэслэн гэрчилнэ” гэж заасан боловч гарал үүслийн бичгийг биржийн тодорхойлолтыг үндэслэхгүйгээр мөн хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээнд танхимын тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэж заасныг үндэслэн шууд олгож байна.

Ийнхүү Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь гарал үүслийн бичгийг олгоходоо биржийн тодорхойлолтыг үндэслэхгүй олгож байгаа нь эрх бүхий байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй байгаа нь хуулийн уг эрх зүйн зохицуулалтын хүчин чадлыг дордуулах, хууль хэрэгжихгүй байх үндсэн нөхцөлийг бүрдүүлэхэд хүргэж байна.

Энэ нь биржээр арилжаагүй бараа, түүхий эд экспортод гарах, биржийн тодорхойлолт шаардахгүйгээр гаалийн бүрдүүлэлт хийх нөхцөл бүрдсэн байна.

- Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “биржийн арилжаанд оролцогчийг сургах, мэргэшүүлэх, итгэмжлэл олгох” гэж заасны дагуу СЗХ-ноос холбогдох нөхцөл, шаардлагыг хангасан хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос гадна биржийн арилжаанд оролцох мэргэжлийн /брокерийн/ ажил үйлчилгээ явуулах эрх олгох сургалтыг явуулдаг байна.

Эхний удаагийн сургалтыг 2013 оны 01 дүгээр сард Биржийн зохицуулах зөвлөлийн Ажлын албатай хамтран зохион байгуулж 92 иргэн, 2 дахь удаагийн сургалтыг 2014 оны 6 сард “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэгч мэргэшсэн брокеруудын нэгдсэн холбоо” болон Биржийн зохицуулах зөвлөлийн ажлын албатай хамтран зохион байгуулж, 29

иргэнийг хамруулж, биржийн арилжаанд оролцох мэргэжлийн /брокерийн/ ажил, үйлчилгээ явуулах эрх, сертификатыг тус тус олгосон байна.

- Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8-д тусгагдсан “биржийн арилжаанд оролцогчийн хүсэлтээр бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг хянан баталгаажуулах” гэсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд биржийн арилжааны гэрээнд үнэ, чанар, тоо хэмжээ, хүргэлтийн байршил зэрэг үзүүлэлтүүд тусгагдаж байгаа ч чанарын баталгаажуулалт хийгддэггүй байна.

Бодит байдалд чанарын баталгаажуулалт хийх техникийн болон бусад шаардлагатай нөхцөл бүрдээгүй, эрх зүйн нарийвчилсан зохицуулалт дутмаг байгаа нь хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна. Тухайлбал, Биржийн барааны шинжээч бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг нүдэн баримжаагаар тогтоодог, зөвхөн байгаа эсэхийг л харж хяналт тавьж байгаа нь бараа, түүхий эдийн чанарыг лабораторийн дүгнэлтээр хянан баталгаажуулах талаар нарийвчилсан эрх зүйн зохицуулалт үгүйлэгдэж байгааг харуулж байна.

- Мөн хуулийн 5.1.9-т заасан “биржийн арилжааны явцад зохиомлоор үнэ өсгөх, бууруулах оролдлого хийж байгаа эсэхэд хяналт тавих, таслан зогсоох” чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд бирж нь арилжааны журмын 5.10-т заасан арилжааны үеэр тогтох үнийг хязгаарлаж, хяналтыг хэрэгжүүлэх журмын дагуу үнэ өсгөх, бууруулах хяналт тавьж ажилладаг байна. Энэ журмын дагуу Бирж дараах жишиг үнэ, баримтлах үнийг тогтоон үнийн хяналтыг хийдэг байна.

Жишиг үнэ: Фьючерс, форвард, опцион гэрээний жишиг үнэ нь өмнөх өдрийн хаалтын үнэ. Спот гэрээний жишиг үнийг Биржийн үнэ, зэрэгцээ зах зээлийн үнэ, гадаад зах зээлийн үнэ, валютын ханшийн өөрчлөлт зэргийг тооцож EWMA аргачлалаар тогтооно.

Баримтлах үнэ: Хамгийн сүүлд биелсэн хэлцлийн үнэ. Тухайн гэрээний арилжааны үнэд жишиг үнэ болон баримтлах үнээс дээш доош тодорхой хувиар үнийн хязгаарлалтыг хийх ба хязгаарлалтын хэмжээг “Биржийн стандарт гэрээ”-д заасан журмыг баримтлан ажиллаж байна.

- Мөн хуулийн 5.1.7-д “энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсноос бусад нэр төрлийн бараа, түүхий эдийг биржээр арилжих жагсаалтыг батлах” гэж заасан.

ҮХААС-ын 2013 оны А/35 дугаар тушаалаар баталсан жагсаалтад ороогүй бараа, түүхий эдийг биржээр арилжихтай холбоотой Удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захирлын шийдвэр гараагүй, энэ төрлийн арилжаа хийгдээгүй байна.

Түүнчлэн хуульд сайд болон биржийн удирдлагын батлах бараа, түүхий эдийн жагсаалтыг ямар шалгуураар хооронд нь зааглах асуудал тодорхойгүй, жагсаалт батлах эрх бүхий этгээдийн эрх хэмжээний хүрээ хязгаар, зааг, ялгаа зохицуулалтгүй орхигдсон байна.

Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11-т тусгагдсан биржийн стандартын шаардлага хангасан агуулах, тээврийн байгууллага, лабораторит итгэмжлэл олгох чиг үүргийг хэрэгжүүлэн биржийн “Итгэмжлэлийн журам”-д заасан тавигдах шаардлага, шалгуурыг хангасан этгээдтэй “Итгэмжлэлийн гэрээ”-г байгуулан ажиллаж байна.

Хүснэгт 8. Итгэмжлэгдсэн этгээдийн мэдээлэл:

Он	Итгэмжлэгдсэн агуулах		Итгэмжлэгдсэн тээврийн байгууллага	Итгэмжлэгдсэн лаборатори	Нийт итгэмжлэгдсэн агуулах, тээврийн байгууллагын тоо
	Улаанбаатар хотод	Орон нутагт			
2013	20	18	2	-	40
2014	20	4	-	-	24
2015	16	11	-	-	27
2016	21	7	-	-	28
2017	9	-	1	-	10
2018	21	2	1	-	24
2019	18	2	-	-	20
2020	16	3	-	-	19
2021 /10 сар/	16	17	-	14	34

2021 онд биржээр хүнсний буудай арилжих бэлтгэл ажлыг хангахтай холбоотойгоор Хөдөө аж ахуйг дэмжих сангийн 5 лаборатори, гурилын үйлдвэрүүдийн 9, нийт 14 лабораторит итгэмжлэл олгоод байна.

Итгэмжлэгдсэн тээврийн байгууллагад итгэмжлэл олгоход ачаа тээвэрлэлтийн нэгдсэн бодлого, үйл ажиллагаа, төрийн болон хувь хүмүүсийн хооронд ачаа тээвэрлэх, хяналтын зохицуулалт муу, малчин, хоршоо, аж ахуйн нэгжүүд ноолуур гэх мэт үнэ цэнэтэй бараа, түүхий эдээ өөрсдөө гардан тээвэрлэх хүсэлтэй байдгаас үүдэн даатгуулах болон тээвэрлэхтэй холбоотой хүндрэл бэрхшээл тулгардаг байна.

Биржийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3-т “бараа, түүхий эдийг хүлээн авах, хадгалах, бэлтгэх зориулалтын итгэмжлэгдсэн агуулахтай байх, эсхүл итгэмжлэгдсэн агуулах бүхий этгээдтэй гэрээ байгуулсан байх” гэж заасан боловч хөдөө, орон нутагт брокерууд идэвхтэй ажиллахгүй байна. Итгэмжлэгдсэн лаборатори болон тээврийн байгууллага цөөхөн, өөрийн агуулах байхгүй, брокерууд УБ хотод байрлах өөрсдийн итгэмжлэгдсэн агуулахад түүхий эдээ байршуулж, арилжаанд оруулдаг байна.

Мөн ХААБ нь өөрийн гэсэн лаборатори, агуулахгүй бөгөөд брокеруудын өөрсдийнх нь агуулахуудад итгэмжлэл олгож, тэднээс итгэмжлэлийн төлбөр, хураамж авч байгаа нь арилжаанд оролцогчдын зүгээс шүүмжлэл дагуулсан зохицуулалт болсон байна.

Биржээс агуулах, тээврийн байгууллага, лабораторит итгэмжлэл олгож буй асуудлыг дахин нарийвчлан судалж, хуулиудын уялдаа холбоог хангаж, зохицуулах нь зүйтэй гэсэн байр суурийг салбарын яам баримталж байна.

Үнэлэх хэсэг	<p>7 дугаар зүйл. Биржийн арилжааны төрөл, хэлбэр</p> <p>7.1.Биржээр зориулалтын байранд, эсхүл цахим сүлжээг ашиглан дуудлага худалдааны хэлбэрээр дараах төрлийн гэрээг арилжина:</p> <p>7.1.1. шууд арилжих гэрээ /spot/;</p> <p>7.1.2. хугацаат гэрээ /форвард/ ;</p> <p>7.1.3. нэг загварын гэрээ /фьючерс/;</p> <p>7.1.4. ирээдүйд худалдах, худалдан авах гэрээ /опцион/.</p>
--------------	--

Томьёолсон шалгуур үзүүлэлт	- Биржийн арилжааны төрлүүд оролцогчдын хэрэгцээ, шаардлага, зах зээлийн зарчимд нийцэж байгаа эсэх? - Арилжааны төрлүүдийн хэлбэрийг сайжруулах шаардлагатай эсэх?
-----------------------------	--

Бирж нь хуульд заасан 4 төрлийн арилжааны гэрээнээс одоогоор **шууд арилжих гэрээ** буюу **/спот/** гэрээг явуулж, форвард арилжаа хийхээр судалгаа хийж, 2017 онд баталсан “Биржийн стратеги төлөвлөгөө”-нд тусган хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Өнгөрсөн хугацаанд буюу 2017 онд-1, 2018 онд-1 удаа форвард гэрээний арилжаа зохион байгуулсан байна.

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжаа нь бүрэн хөгжөөгүй, зах зээлийн голлох дэд бүтцийн нэг болсон арилжааг олон улсын жишгийн дагуу зохион байгуулж чадахгүй байна.

Цаашид арилжаа, арилжааны үйл явц, төлбөр тооцоо, арилжаанд оролцогчид, зуучлагч, бусад мэргэжлийн байгууллага, хөрөнгө оруулагч, бэлтгэн нийлүүлэгч, хадгалалт, хамгаалалт болон бирж дээр арилжаалах үүсмэл гэрээ, тэдгээр нь үнэт цаасанд хамаарах эсэх талаар, үүсмэл гэрээний стандарт, тэдгээрийг арилжаалахтай холбоотой зохицуулалт зэргийг тодорхой тусгаж, арилжаа явуулах зах зээлдээ чиглэсэн харилцааг нарийн зохицуулсан, санхүүгийн зах зээлийн бүтээгдэхүүн бий болгоход чиглэсэн эдийн засгийн агуулгаар өөрчлөх шаардлагатай байна.

Үнэлэх хэсэг	8 дугаар зүйл. Биржийн зохицуулах зөвлөл 8.5.Зохицуулах зөвлөл нь дараах чиг үүрэгтэй: 8.5.1.энэ хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэл өгөх; 8.5.2.биржийн арилжааны зах зээлд оролцогчийн үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах; 8.5.3.биржийн үйл ажиллагааны чиглэлээр зөвлөмж, дүгнэлт гаргах. 8.5.6 Зохицуулах зөвлөлийн дүрэм, үйл ажиллагааны журмыг Засгийн газар батална. 8.7. Зохицуулах зөвлөл үйл ажиллагаагаа Засгийн газарт тайлагнана.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	- Зохицуулах зөвлөл нь хуулиар олгосон чиг үүргээ хангалттай түвшинд хэрэгжүүлэн ажиллаж чадаж байгаа эсэх? - Зохицуулах зөвлөл нь хуулийн хэрэгжилтийг хангуулах болон биржийн арилжааны зах зээлд оролцогчийн үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс ямар үр дүн гарсан? - Зохицуулах зөвлөл нь хуулийн зорилгыг хангахад дэмжлэг үзүүлсэн эсэх? - Зохицуулах зөвлөл бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хүндрэл байгаа эсэх?

Хуулийн 8 дугаар зүйлд бирж нь биржийн арилжааны зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах зорилготой орон тооны бус биржийн Зохицуулах зөвлөлтэй /цаашид “Зөвлөл” гэх/ байна гэж заасан.

Зохицуулах зөвлөл нь төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн нийт 13 гишүүнтэй байхаар хуульд зааснаас төрийн байгууллагын төлөөлөлд Гааль, Татвар, Мэргэжлийн хяналт, Стандартчилал хэмжил зүйн байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн хороо гэсэн 6 төлөөлөл, төрийн бус байгууллагын төлөөлөлд биржийн арилжааны зах зээлд оролцогчдыг төлөөлсөн Мэргэжлийн холбоод, биржийн брокер болон хоршоодын төлөөллөөс 7 гишүүд байна.

Биржийн Зохицуулах зөвлөлийн гишүүдийг холбогдох төрийн захиргааны байгууллагын санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлж, зөвлөлийн дүрэм, үйл ажиллагааны журмыг мөн Засгийн газар батлахаар заасны дагуу Засгийн газрын 2012 оны 188 дугаар тогтоолоор

Зохицуулах зөвлөлийн чиг үүрэг, зохион байгуулалт, ажиллах зарчмыг тодорхойлсон “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн зохицуулах зөвлөлийн дүрэм”-ийг, хавсралтаар “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус баталсан байдаг.

Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг нийт 3 удаа шинэчилсэн бөгөөд хамгийн сүүлд Засгийн газрын 2017 оны 27 дугаар тогтоолын 13 дугаар хавсралтаар мөн шинэчлэн баталжээ. Засгийн газраас 2012 онд баталсан “Хөдөө аж ахуйн гаралтай, түүхий эдийн биржийн зохицуулах зөвлөлийн дүрэм”-ээр Зохицуулах зөвлөлд чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслах, зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, үр дүнг нэгтгэн дүгнэж зөвлөлийн хуралд оруулах зэрэг чиг үүрэг бүхий ажлын албатай байхаар баталж, 2013-2016 онуудад үйл ажиллагаа явуулсан боловч 2016 онд биржийн тухай хуульд өөрчлөлт оруулж, биржийн Зохицуулах зөвлөлийн ажлын албыг татан буулгасан байна.

Зохицуулах зөвлөл нь төрийн бодлого болон хуулийн хэрэгжилтийг хангах, цаг үеийн тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэх, биржийн үйл ажиллагаанд оролцогч төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, арилжаанд оролцогчдын үйл ажиллагааг уялдуулах, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, биржийн үйл ажиллагааг зохицуулах, биржийн бодлогыг тодорхойлох, дүрэм, журам, стандартыг батлах зэрэг чиг үүрэгтэй.

Гэвч сүүлийн 5 жилийн хугацаанд 4 удаа хуралдаж, 2015-2016 онд 3 удаа л зөвлөмж гаргасан нь хуулийн хэрэгжилтийг хангуулах болон биржийн арилжааны зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг уялдуулах чиглэлээр хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж хуулийн зорилгыг хангахад дэмжлэг үзүүлж ажиллаагүй байна.

Зохицуулах зөвлөлөөс гарсан зөвлөмж:

1. “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам батлан гарахтай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 01 тоот зөвлөмж. (2015 оны 05 дугаар сарын 28);
2. “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 01 тоот зөвлөмж. (2016 оны 01 дүгээр сарын 22);
3. “Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны ерөнхий журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 02 тоот зөвлөмж. (2016 оны 05 дугаар сарын 06)

Мөн 2017 онд байгуулагдсан Зохицуулах зөвлөл 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хуралдаж Биржийн үйл ажиллагаа, 2018 оны ажлын төлөвлөгөө, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх талаар хэлэлцсэн ч зөвлөмж гараагүй байна.

Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны журамд зааснаар Зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдаж тогтоол, зөвлөмж, дүгнэлт гаргахаар заасан ч сүүлийн 3 жилийн хугацаанд 1 ч удаа хуралдаагүй нь биржийн үйл ажиллагааг дэмжих, эрчимжүүлэх талаар тодорхой ажил хийгдээгүй, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна гэж дүгнэж байна.

Мөн хуулийн 5.2-т заасан биржийн арилжааны зах зээлд оролцогчдын нийтлэг үйл ажиллагааг зохицуулсан нэр бүхий 13 заалтад хамаарах журмыг Биржийн зохицуулах зөвлөлөөр хэлэлцүүлэн баталж, мөрдүүлэхээр заасан бөгөөд дараах 3 журмаар нэгтгэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөж байна. Үүнд:

- “Итгэмжлэлийн журам”/2021.01.07/;
- “Арилжааны журам”/2016.04.06/;
- “Төлбөр тооцооны журам”/2017.02.08/-аар тус тус нарийвчлан зохицуулж байна.

Хүснэгт 9. Нэгтгэсэн журмуудаар зохицуулж байгаа харилцаа

“Итгэмжлэлийн журам”-аар зохицуулж байгаа:	“Арилжааны журам”-аар зохицуулж байгаа:	“Төлбөр тооцооны журам”-аар зохицуулж байгаа:
5.2.1.бараа, түүхий эдийг бэлтгэх, хаяглах, хадгалах, тээвэрлэх;	5.2.4.биржээр арилжих гэрээний стандарт тогтоох, мөрдүүлэх;	5.2.7.биржийн арилжааны төлбөр тооцоо хийх;
5.2.2.бараа, түүхий эдийг бүртгэх;	5.2.5.биржийн арилжааг зохион байгуулах;	5.2.12.биржийн дэнчингийн хувь хэмжээг тогтоох;
5.2.3.бараа, түүхий эдийг агуулахад хүлээн авах;	5.2.6.биржийн арилжааны үнэ бүрдэлтэд хяналт тавих;	5.2.13.баталгааны санд биржийн дэнчин байршуулах, үүргийн гүйцэтгэлийг хангуулах;
5.2.10.энэ хуулийн 5.1.11-д заасан агуулах, тээврийн байгууллага, лабораторит итгэмжлэл олгох;	5.2.8.энэ хуулийн 4.3-т заасан мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах;	
5.2.11.биржээр арилжих бараа, түүхий эдийн гарал үүсэл, чанарыг баталгаажуулах;		

Одоогийн биржийн Зохицуулах зөвлөлийн үүргийг 2017 онд төрийн захиргааны байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас байгуулсан Удирдах зөвлөл хэрэгжүүлж байгаа ч үйл ажиллагаа, оролцоо нь тодорхой бус бодитой гарсан үр дүн үнэлгээ хийх явцад төдийлөн харагдахгүй байна.

Биржийн хуулиар биржийн зохицуулах зөвлөл нь биржийн дүрмийг батлах үүрэгтэй хэдий ч Хөдөө аж ахуйн бирж өөрөө баталж, хэрэгжүүлж байгаа нь хуулийн хэрэгжилтийг хангахгүй байна⁶.

Нөгөө талаас биржийн арилжаанд оролцогчидтой хийсэн уулзалт, ярилцлагад тухайн үүссэн асуудлыг шийдвэрлэхээр хандах үед “Биржийн зохицуулах зөвлөл байхгүй учраас боломжгүй” гэдэг тайлбарыг өгдөг боловч бирж өөрийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шийдвэрлэх болохоор Удирдах зөвлөлийн шийдвэр гаргах замаар шийдвэрлэж байгаа нь адил тэгш байх зарчмыг баримтлахгүй байна гэсэн шүүмжийг үнэлгээний явцад оролцогчид хэлж байсныг дурдаж болох юм.

Биржийн арилжаанд оролцогч төрийн хяналтын байгууллагууд, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, хоршоод, малчид, тариаланчид, үйлдвэрүүд, брокеруудын үйл ажиллагааг уян хатан, оновчтой байдлаар зохицуулах, тэдгээрийн үүрэг, оролцоог тодорхой болгох, идэвхжүүлэхэд зохион байгуулалт, менежментийн арга хэмжээ авах асуудлыг шийдвэрлэхэд Зохицуулах зөвлөлийн үүрэг оролцоо, шийдвэрлэх шаардлагатай асуудлууд байсаар байна.

Иймээс биржийн үйл ажиллагааг оновчтой, тухайн цаг үе, нөхцөл байдалд тохируулан шуурхай удирдлагаар хангахад хуулиар эрх олгосон Биржийн зохицуулах зөвлөл, эсвэл хуулиар тусгайлан эрх олгогдоогүй, сайдын баталсан Удирдах зөвлөл чиг үүргээ хэрэгжүүлэх үү гэдэг асуудал тодорхойгүй байна.

Хэрвээ биржийн Удирдах зөвлөл нь Зохицуулах зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэхээр бол мэргэжлийн холбоо, хоршоо, үйлдвэр, брокер зэрэг бусад арилжаанд оролцогчдын төлөөллийг оролцуулах нь зүйтэй юм.

⁶ Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн стратегийн төлөвлөгөө боловсуурлах судалгааны ажил – Дунд шатны тайлан-2, ХХААХҮЯ, 2021.

<p>Үнэлэх хэсэг</p>	<p>9 дүгээр зүйл. Биржийн ажилтанд хориглох зүйл</p> <p>9.1.Биржийн ажилтанд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:</p> <p>9.1.1.биржийн арилжаанд оролцох;</p> <p>9.1.2.биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн компани байгуулах;</p> <p>9.1.3.биржийн арилжаанд оролцогчийн арилжааны нууцыг агуулсан мэдээ, мэдээллийг хувийн ашиг сонирхолд ашиглах, бусдад задруулах;</p> <p>9.1.4.биржийн арилжааны зуучлагч /брокер/-тай үгсэн хуйвалдаж биржийн арилжааг шударга бусаар явуулах;</p> <p>9.1.5.бараа, түүхий эдийн үнэд нөлөөлж болох мэдээллийг орхигдуулах, нуун дарагдуулах, зохих журмын дагуу мэдээлэл өгөхөөс татгалзах;</p> <p>9.1.6.ажил, үүргээ гүйцэтгэснийхээ төлөө бусад этгээдээс урамшуулал, мөнгөн шагнал, шан харамж авах.</p>
<p>Томьёолсон шалгуур үзүүлэлт</p>	<ul style="list-style-type: none"> - Биржийн ажилтанд хориглосон үйл ажиллагааг зөрчсөн талаарх тоон мэдээлэл, учруулсан хохирлын хэмжээ, авсан арга хэмжээ? - Сонирхлын зөрчлөөс сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээ зохион байгуулдаг эсэх?

"Хөдөө аж ахуйн бирж" ХХК байгуулагдсан цагаас хойш "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлд заасан "Биржийн ажилтанд хориглосон үйл ажиллагаа"-г зөрчсөн үндэслэлээр сахилгын шийтгэл хүлээсэн ажилтан байхгүй байна.

Ажилтнуудыг ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт ажилтнуудаас нэгдмэл сонирхолтой этгээдийн судалгааг авдаг бөгөөд Компанийн эрх бүхий албан тушаалтныг томилохын өмнө хуульд заасны дагуу Хувийн ашиг сонирхлын урьдчилан мэдүүлэг бөглүүлж, Авлигатай тэмцэх газраас зөвшөөрөл ирсний дараа томилж, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлж байна.

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж байгаа сургалтуудад ажилтнуудыг үе шаттай хамруулж, шилэнд дансанд ашиг сонирхлын талаарх мэдээллийг сар тутам мэдээллэж ажилласан байна.

2.2. БИРЖИЙН АРИЛЖААНД ОРОЛЦОГЧ

<p>Үнэлэх хэсэг</p>	<p>10 дугаар зүйл. Биржийн арилжаанд оролцогч</p> <p>10.1.Биржийн арилжаанд оролцогчийг байнгын болон байнгын бус гишүүн оролцогч гэж ангилна.</p> <p>10.4.Биржийн байнгын гишүүн оролцогч биржийн арилжаанд оролцох тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дөрөвдүгээр бүлэгт болон энэ хуулийн 11.2.3, 11.2.6-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд авна.</p> <p>10.6.Биржийн байнгын бус гишүүн оролцогч биржийн арилжаанд оролцох зөвшөөрлийг биржээс авсан байна.</p> <p>10.7.Хоршоо нь анхан шатны тордолт хийж стандартын шаардлага хангасан бараа, түүхий эдийг биет байдлаар нийлүүлэх гэрээ байгуулж биржийн арилжаанд оролцоно.</p> <p>10.8.Гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн биржийн арилжаанд биржийн байнгын гишүүн оролцогчоор зуучлуулан оролцоно.</p>
---------------------	---

Томьёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> - Биржийн арилжаанд оролцогч брокер болон хоршоод арилжаанд тэнцвэртэй, тэгш, шударга оролцох боломжоор хангагдаж чадаж байгаа эсэх? - Биржийн арилжаанд оролцогчдод тулгарч буй хүндрэл, бэрхшээл? - Малчид, тариаланчид, үйлдвэрлэгчид биржийн арилжаанд шууд оролцож улмаар хуулийн зорилгыг хангахад дэмжлэг үзүүлсэн эсэх? - Хоршоо нь анхан шатны тордолт хийж стандартын шаардлага хангасан бараа, түүхий эдийг биет байдлаар нийлүүлэх гэрээ байгуулж биржийн арилжаанд оролцоно гэсэн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?
-----------------------------	--

Хуулиар биржийн арилжаанд оролцогчийг байнгын буюу брокер, байнгын бус гишүүн оролцогч буюу хоршоо гэж ангилан, биржийн брокер нь үндэсний, эсвэл үндэсний хөрөнгө оруулалт давамгайлсан хуулийн этгээд байхаар зохицуулан арилжаанд оролцуулж байна. Харин байнгын бус гишүүн нь биржээс тавьж буй шаардлага, шалгуурыг хангасан хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршоо байх зохицуулалттай.

Биржийн брокер нь биржээс суудлын эрх авч, СЗХ-ноос арилжааны тусгай зөвшөөрөл авч оролцдог бол хоршоо нь биржээс зөвшөөрөл авч, нэг удаагийн төлбөр төлж оролцож байна. СЗХ-оос тавьсан мэргэжлийн болон санхүүгийн шаардлагыг хангах аж ахуйн нэгж, хоршоод байгаагүй бөгөөд харин тухайн үеийн ченжүүд энэ шаардлага, нөхцөлийг хангаж, брокерийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 10. Биржийн арилжаанд оролцогчдын тоон мэдээлэл:

<i>д/д</i>	<i>Он</i>	<i>Байнгын /брокер/ гишүүний тоо</i>	<i>Байнгын бус /хоршоо/ гишүүний тоо</i>
1	2013 он	32	-
2	2014 он	20	-
3	2015 он	8	-
4	2016 он	11	-
5	2017 он	15	-
6	2018 он	10	3
7	2019 он	5	2
8	2020 он	8	-
9	2021 он	6	1

Эх сурвалж: ХХААХҮЯ-наас ирүүлсэн мэдээлэл

2021 оны байдлаар СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авсан, суудлын эрхтэй, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 6 брокер, биржээс зөвшөөрөл авсан 1 хоршоо байна. Дээрх хүснэгтээс харахад биржийн хууль батлагдах үед СЗХ-ноос тусгай зөвшөөрөл авсан байнгын гишүүн оролцогчийн тоо 2013 онд 32, 2014 онд 20 гэх зэргээр жил ирэх тусам буурсаар энэ онд 6 брокер л үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авч, биржтэй гишүүнчлэлийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Харин 2018 онд 3 хоршоо, 2019 онд 2, 2021 онд 1 хоршоо тус тус арилжаанд оролцох зөвшөөрөл авсан байна. ХХААХҮЯ-наас ирүүлсэн мэдээлэлд дурдсан хоршоодын тоон мэдээлэл, ХААБ-ээс ирүүлсэн статистик тоо зөрүүтэй байна.

2020 оны байдлаар улсын хэмжээнд 4580 хоршоо, 235 мянга гаруй гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулж, бүх аймаг, сумдад тодорхой хэмжээний малчид, малчдын бүлгэмийг үүсгэн хөдөө аж ахуйн бараа, түүхий эдээ борлуулж байгаа ч биржийн арилжаанд идэвхтэй оролцохгүй байна. Хоршоод биржийн байнгын бус гишүүнээр арилжаанд оролцох эрх нь

нээлттэй байгаа хэдий ч өнөөг хүртэл оролцоо сул, биржийн арилжаанд тогтмол оролцдоггүй, оруулсан захиалга биелэхгүй байсан зэргээс шалтгаалсан арилжааны зуучлагчийн үндсэн үүргийг хэрэгжүүлэх боломжгүй байна⁷.

Хоршоод биржийн арилжаанд орохгүй байгаа гол шалтгаан нь ихэнх малчдын хоршооны хувьд биржээс тавигдаж байгаа ажлын байрны шаардлага /байнгын ажлын байр, компьютер, интернет сүлжээ г.м/ хангах боломжгүй, бирж тэрхүү асуудлыг шийдвэрлэх гэхээр төрийн өмчит компани тул ийм төрлийн зардлууд төсөвт тусгагдаагүй, биржээр арилжих бараа, түүхий эдийг хадгалах, анхан шатны тордолт хийх боломжтой итгэмжлэгдсэн агуулах хомс, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо бүрдээгүй, дундын зуучлагч болох ченжээр дамжуулан малчид түүхий эдээ борлуулж хэвшсэн зэрэгтэй холбоотой байна.

Мөн хоршоодыг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааг өргөжүүлэх олон арга хэмжээ авч хэрэгжүүлсээр ирсэн ч жинхэнэ утгаар нь ажиллаж, бодит үйл ажиллагаа явуулж байгаа малчдын хоршоо цөөхөн байна. Хоршоо дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр шимийг малчдын хоршоод хүртэж чадахгүй, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжсэн оновчтой, бодитой дэмжлэг болж чадахгүй байгаагаас шалтгаалан хоршоодын тоо төдийлөн нэмэгдэхгүй байна.

2021 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Монгол Улсын Их Хурлаар Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, хоршоодын үйл ажиллагааг дэмжсэн, хоршооллын хөдөлгөөнийг идэвхжүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн олон өөрчлөлтийг оруулснаас гадна 2022 оныг “Хоршооны хөгжлийг дэмжих жил” болгон хоршооллын хөдөлгөөнийг эрчимжүүлэх, загвар хоршоодыг байгуулах, сайн туршлагыг нэвтрүүлэх, хөдөө аж ахуйг цахимжуулах, ХАА-н биржийн үйл ажиллагааг хоршооны үйл ажиллагаатай уялдуулах зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлсэн байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар “хоршооны гишүүдийнхээ барааг дотоодын үйлдвэрлэгчдэд зуучлан борлуулсан орлого нь НӨАТ-аас чөлөөлөгдөх” өөрчлөлтийг оруулж, хоршоогоор дамжуулан түүхий эд, бараагаа дундын олон дамжлагагүйгээр өндөр үнээр борлуулах боломж бий болж байна. Малчид боловсруулсан бараа, түүхий эдээ борлуулахдаа улсад татвар төлдөггүй, харин дамжуулан борлуулж буй брокерууд 10 хувийн татвар төлж байна.

Байнгын гишүүн оролцогчдын хувьд СЗХ-ноос олгодог тусгай зөвшөөрлийн шалгуур үзүүлэлт хэт өндөр байгаагаас гишүүдийн тоо нэмэгдэх боломж хомс байдаг хэдий ч нөгөө талаас санхүүгийн эрсдэл өндөртэй институтийн хувьд шаардлага өндөр байх нь тэр хэмжээгээр эрсдэлээс хамгаалж байна гэж харж байна.

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн стратегийн төлөвлөгөө боловсруулах судалгааны ажил /Дунд шатны тайлан-2/ тайланд хоршоод бэлтгэсэн бараа, түүхий эдээ биржээр арилжих оролдлого олон удаа хийж байсан ч дундаас нь брокерууд оролцож, түүхий эдийг нь шууд худалдан авдаг, биржийн арилжаанд хоршоо болон брокерууд тэгш, шударга оролцох зохицуулалттай хэдий ч тус зохицуулалтын хэрэгжилт хангагдахгүй байгааг онцолсон байна.

Хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа брокер болон хоршоодын биржийн арилжаанд оролцох идэвх сул, өөрсдийн бэлтгэсэн бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд шууд худалдаалж чадахгүй, ченж буюу борлуулагчдаар дамжуулж борлуулсан хэвээр байна.

⁷Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, ХААБ, 2021 он.

Иймд орон нутгийн түүхий эд бэлтгэн нийлүүлэлтэд хоршооны оролцоог нэмэгдүүлэх, малчид хоршоологчдод чиглэсэн сургалт, танин мэдэхүйн ажил дутагдалтай байна. Бараа, түүхий эдийн нөөцийн дийлэнх хэсгийг биржээр дамжуулан үйлдвэрүүд болон гадаад зах зээлд арилжих нөхцөлийг бүрдүүлж, биржийн арилжаанд малчид, тариаланчид хөдөө, орон нутгаас шууд оролцох боломжийг бүрдүүлэх нь чухал байна.

Биржийн арилжааны зах зээлийн харилцаанд оролцогчдын тэр дундаа малчид тариаланчид, хоршоологчдын хөдөө аж ахуйн биржийн талаарх ерөнхий ойлголт, улс орон болон эдийн засагт үзүүлэх эерэг үр нөлөө, боломжийн талаарх мэдлэг бага, тэдэнд чиглэсэн сургалт, таниулах ажил хангалттай хийгдэхгүй байгаагаас шалтгаалан биржийн арилжаанд оролцогч хоршоодын тоо нэмэгдэхгүй байна.

Мөн стандартын шаардлага хангасан агуулах, тээврийн байгууллага, лабораторит итгэмжлэл олгох чиг үүргийг энэхүү хуулиар бирж эдэлдэг боловч одоогийн байдлаар зөвхөн агуулахын итгэмжлэл олгох ажил л хийгдэж байна. Тээврийн байгууллагад итгэмжлэл олгох асуудал нь 2017 онд “Монгол тээвэр нэгдэл” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байсан боловч биржээр арилжиж буй бараа, түүхий эдийг уг тээврийн байгууллагаар тээвэрлэсэн зүйл байхгүй, лабораторийн хувьд итгэмжлэл олгож, хамтран ажилласан тохиолдол байхгүй байна. Өөрөөр хэлбэл энэ заалт хэрэгжээгүй гэж үзэхээр байна⁸.

Бирж байгуулагдахаас өмнө ченжүүд нь гадаадын худалдаачдын мөнгөөр хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг худалдан авч, хууль бусаа экспортолдог байсан бол хууль батлагдсанаар албажиж, бүртгэлжиж, биржээс шаардсан төлбөр, хураамжийг төлж, экспортолдог тогтолцоонд шилжсэн байна. Нийт 10 гадаадын иргэн, харилцагч биржийн байнгын гишүүн 4 брокерын компаниар зуучлуулан биржийн арилжаанд оролцсон гэх мэдээллийг ХХААХҮЯ-наас ирүүлсэн.

<p>Үнэлэх хэсэг</p>	<p>11 дүгээр зүйл. Биржийн арилжаанд оролцогчийн эрх, үүрэг</p> <p>11.1.Биржийн арилжаанд оролцогч нь дараах нийтлэг эрх, үүрэгтэй:</p> <p>11.1.2.стандартын /бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, баглаа боодлын/ дагуу бэлтгэн сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасгийн мэдээллийн санд бүртгүүлж, мал эмнэлгийн болон лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээ авсан бараа, түүхий эдийг арилжих;</p> <p>11.2.Биржийн байнгын гишүүн оролцогч нь энэ хуулийн 11.1-д зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:</p> <p>11.2.1.суудлын эрх авах;</p> <p>11.2.3.бараа, түүхий эдийг хүлээн авах, хадгалах, бэлтгэх зориулалтын итгэмжлэгдсэн агуулахтай байх, эсхүл итгэмжлэгдсэн агуулах бүхий этгээдтэй гэрээ байгуулсан байх;</p>
<p>Томьёолсон шалгуур үзүүлэлт</p>	<ul style="list-style-type: none"> - Оролцогчийн эрх, үүрэг хуулиар бүрэн зохицуулагдаж чадаж байгаа эсэх? - Мал, эмнэлгийн болон магадлан шинжилгээний гэрчилгээ нь түүхий эдийн чанарыг баталгаажуулж чадаж байгаа эсэх? - Суудлын эрхтэй байнгын гишүүн оролцогчид олгогдсон давуу эрх? - Бараа, түүхий эдийг хүлээн авах, хадгалах, бэлтгэх итгэмжлэгдсэн агуулахын тоо? - Хориглосон үйл ажиллагаа явуулсан оролцогчдод хариуцлага тооцсон талаарх мэдээлэл? Цаашид биржийн арилжаанд оролцох эрхийг хөнддөг эсэх?

⁸ Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, ХААБ, 2021 он.

Биржийн арилжаанд оролцогчийн эрх, үүрэг нь Биржийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолоор баталсан "Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагааны зохицуулалтын журам болон Биржийн гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан Арилжааны журам, Төлбөр тооцооны журам, Гишүүнчлэлийн журам, Итгэмжлэлийн журмаар нарийвчлан зохицуулагдсан.

Стандартын /бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, баглаа боодлын/ дагуу бэлтгэн сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасгийн мэдээллийн санд бүртгүүлж, мал эмнэлгийн болон лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээ авсан бараа, түүхий эдийг арилжих" гэсэн эрх, үүргийн хэрэгжилттэй холбоотойгоор зарим асуудал үүсдэг байна. Тухайлбал, холбогдох журамд хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг үндэсний стандартын дагуу бэлтгэн холбогдох баталгаажуулалт, хяналтыг хийсний үндсэн дээр арилжаанд оруулахаар тусгасан хэдий ч стандартын дагуу бэлтгэн нийлүүлэхгүй байгаагаас түүхий эдийн чанар муудахад нөлөөлж байна. Нөгөө талаас биржээр арилжих бараанд чанарын хяналтыг холбогдох байгууллагаас хийхгүй байна.

Орон нутагт сумдын хөдөө аж ахуйн газар, мал эмнэлэг, үржлийн нэгжээс тодорхойлолт авсаны үндсэн дээр бараа, түүхий эдийг арилжаанд оруулж байна.

ХХААХҮС-ын 2019 оны А-08 дугаар тушаалаар баталсан "Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журам"-д тодорхойлсноор бэлтгэн тээвэрлэх, худалдаалах, хадгалах мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдалд мэдрэхүйн үзлэг, магадлан шинжилгээг хийдэг бөгөөд энэ нь хуульд тодорхойлсон нь түүхий эдийн чанар, стандартыг баталгаажуулах тодорхойлолт биш, мал, амьтны эрүүл мэнд талаас тодорхойлж байгаа тодорхойлолт болдог.

Нөгөө талаас мал эмнэлгийн байгууллага магадлан шинжилгээний түүхий эд бүтээгдэхүүнд ариун цэвэр, эрүүл ахуйн үзлэг хийх, эрүүл мэнд, гарал үүслийг тодорхойлох, магадлан шинжилгээ хийж бүтээгдэхүүний аюулгүй байдлыг тогтоох, лабораторийн магадлан шинжилгээний гэрчилгээ олгохдоо хөдөө аж ахуйн биржийн тодорхойлолтыг шаардаж байгаа нь хууль тогтоомжоор зохицуулаагүй харилцаа болсон байна. Үүнийг төрийн байгууллагууд хоорондоо үгсэх байдлаар үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчдийг боогдуулж байгаа хууль бус үйлдэл гэж төрийн бус байгууллагатай хийсэн ярилцлагаар дурдсан болно.

Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1-т биржийн байнгын гишүүн оролцогчид суудлын эрх авах давуу эрхийг олгосон. Биржийн "Гишүүнчлэлийн үйл ажиллагааны журам"-аар суудлын эрх олгох харилцаа зохицуулагддаг бөгөөд суудлын эрх нь биржийн арилжаанд орох харилцагчдыг биржтэй холбон зуучлах замаар орлогоо нэмэгдүүлэх давуу талтай. Ингэснээр оролцогчдод чанар, стандартын дагуу бэлтгэсэн түүхий эдийг экспортлох боломжтой гэж салбарын яам дүгнэжээ.

Хүснэгт 11. Хураамж, суудлын төлбөрийн хэмжээ

Гишүүний хураамж	Элсэлтийн хураамж	Суудлын хураамж
Байнгын гишүүн оролцогч	4.5 сая төгрөг	2.0 сая төгрөг
Байнгын бус гишүүн оролцогч	-	50.000 төгрөг /нэг удаа/

Биржээс хийсэн Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд "биржийн байнгын болон байнгын бус гишүүн нь биржид хүсэлт гаргасны дагуу гишүүнчлэлийн гэрээг байгуулан ажилладаг бөгөөд хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан "суудлын эрх олгох" гэдэг нэр томъёо практикт хэрэглэгдэхгүй байгаа тул энэхүү нэр томъёог өөрчлөн найруулах шаардлагатай" гэж үзсэн

байна. Бидний хийсэн үнэлгээний явцад тус зохицуулалтын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, тоо баримт бүртгэгдээгүй тул үнэлээгүй болно.

Хуулийн 12 дугаар зүйлд биржийн арилжаанд оролцогчид хориглох зүйлийг дараах байдлаар тодорхойлсон.

- биржийн арилжаанд оролцогч бусад этгээдийн болон түүний бараа, түүхий эдийн нэр хүндийг гутаах, эсхүл өрсөлдөгчөө алдагдалд оруулж болохуйц худал, зөрүүтэй буюу гуйвуулсан мэдээ тараах;
- харилцан тохиролцох замаар биржээр арилжих бараа, түүхий эдийн үнийн түвшинд хязгаар тогтоох;
- өөрийн болон биржийн арилжаанд оролцогч бусад этгээдийн бараа, түүхий эдийг үйлдвэрлэсэн арга, хэрэглээний шинж чанарын гол үзүүлэлт, хэрэглэх аргын талаар худал, зөрүүтэй мэдээлэх, эсхүл үнэн байдлыг гуйвуулах зэргээр бусдыг төөрөгдүүлэх, хуурч мэхлэх;

Үнэлгээний явцад биржийн арилжаанд оролцогчид хориглох зүйлийг зөрчсөн талаарх мэдээлэл бүртгэгдээгүй болно.

2.3. БИРЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

Үнэлэх хэсэг	13 дугаар зүйл. Аудит 13.1.Биржийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд Үндэсний аудитын газар жил бүр аудит хийж дүгнэлт гаргана. 13.2.Үндэсний аудитын газар энэ хуулийн 13.1-д заасан дүгнэлтээ Засгийн газарт танилцуулна.
Томьёолсон шалгуур үзүүлэлт	- Үндэсний аудитын газрын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласнаар гарсан үр дүн? - Засгийн газрын хуралдаанаар дүгнэлтийг хэлэлцээд гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан эсэх?

Хуулийн 13 дугаар зүйлд биржийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд Үндэсний аудитын газар жил бүр аудит хийж, дүгнэлт гаргаж, дүгнэлтээ Засгийн газрын хуралдаанд танилцуулах эрх зүйн зохицуулалтыг тусгасан.

"Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас жил бүр санхүүгийн аудит хийгддэг ба аудитаар компанийн нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт болон тайлан бэлтгэх, тайлагнах үйл ажиллагаанд үүссэн алдаануудад дүгнэлт, зөвлөмж өгдөг байна. Тэдгээр зөвлөмжийн дагуу нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу залруулга хийж хэрэгжүүлсэн тайланг Үндэсний аудитын газрын заасан хугацаанд хүргүүлж тайлагнан ажилладаг байна. Харин Үндэсний аудитын газар нь дүгнэлтээ Засгийн газарт танилцуулна гэсэн заалт хэрэгждэггүй бөгөөд "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн аудитын дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээгүй байна.

Биржийн санхүүгийн болон үйл ажиллагаанд тавих хяналт сул, хэлбэр төдий, дүгнэлт, зөвлөмжийг эрх бүхий байгууллагад тайлагнах тогтолцоо бүрдэж чадаагүй, хяналт тавих эрх бүхий байгууллага хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаагүйгээс хуулийн хэрэгжилт хангалтгүй байх нөхцөл бүрдсэн байна.

Үнэлэх хэсэг	<p>15 дугаар зүйл. Биржийн үйл ажиллагаатай холбогдсон маргааныг шийдвэрлэх</p> <p>15.1.Биржийн гэрээ байгуулах, түүнээс үүсэх эрх, үүрэгтэй холбогдон гарсан маргааныг эрх бүхий байгууллага хянан хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд уг шийдвэрийг эс зөвшөөрвөл талууд шүүхэд гомдол гаргаж болно.</p> <p>16 дугаар зүйл. Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага</p> <p>16.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p>
Томъёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> - <i>Хуулийн хэрэгжилт болон биржийн үйл ажиллагаа</i>, эрх, үүрэгтэй холбоотой асуудлаар шүүхэд гомдол, маргаан гарсан эсэх? - <i>Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээсэн этгээдийн талаарх мэдээлэл?</i>

Хууль хэрэгжих хугацаанд биржийн гэрээ байгуулах, түүнээс үүсэх эрх, үүрэгтэй холбогдон гарсан маргаантай холбоотой 1 гомдол шүүхэд гаргасан байна. Тодруулбал, Биржтэй Гишүүнчлэлийн гэрээ байгуулсан байнгын гишүүн брокерын компани "МЭТУ ХААБ" ХХК нь Биржийн тухай хууль, холбогдох журмууд болон Гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчиж, биржийн арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийг хугацаанд нь төлж барагдуулаагүйгээс биржид 428 сая төгрөгийн хохирол учруулсныг Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хандаж шийдвэрлүүлсэн байна.

Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүсэлт гаргаснаар тус брокерийн компанийн гишүүнчлэлийн болон арилжааны эрхийг цуцалсан байна. Бусад оролцогчдын хувьд хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн ажилладаг байна.

Биржийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж заасан ч тус заалт хэрэгждэггүй. Биржийн хуулийг зөрчиж, биржийн арилжаанд ороогүй бараа, түүхий эдийг экспортод гаргах асуудлууд удаа дараа гарч байгаа нь биржийн арилжааны мэдээ болон гаалийн статистик мэдээ зөрүүтэй байгаагаас харагдаж байна. Биржийн зүгээс энэхүү асуудлаар СЗХ, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Цагдаагийн газар г.м байгууллагуудад хандаж байсан боловч тодорхой үр дүнд хүрээгүй, уг хэргийн мөрөөр ямар арга хэмжээ авч, яаж шийдвэрлэсэн талаар эргэж мэдэгддэггүй зэрэг асуудлууд байна.

Биржийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5, 4.6-д заасны дагуу хөдөө аж ахуйн салбарын сайдын баталсан жагсаалтад орсон бараа, түүхий эд болох ноос, ноолуур, хүнсний буудай, тосны ургамал /рапс/, мал, мах, арьс ширийг экспортод гаргах тохиолдолд биржээр арилжсан байх талаар хуульчилсан. Тус хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж заасан. Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль зөрчих”-тэй холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд энэ хэсгийн 5-д “Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалтад орсон бараа, түүхий эдийг экспортлохдоо биржээр арилжсан байх шаардлагыг зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасан байдаг.

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль зөрчсөн тохиолдолд хэргийн харьяаллын хувьд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.18-д заасны дагуу СЗХ-ны хянан шалгагч зөрчлийн хэрэг үүсгэж, шалган шийдвэрлэхээр зохицуулсан байдаг. Тухайлбал, 2021 онд Биржийн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн нэр бүхий 10 компанид зөрчлийн хэрэг үүсгэж, хариуцлага тооцуулахаар СЗХ-нд хандсан боловч 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс дагаж мөрдсөн Өршөөл үзүүлэх тухай хуульд заасны дагуу тэдгээр

компаниуд тус хуульд хамрагдаж, арга хэмжээ авах боломжгүй талаар мэдэгдээд байна. Биржийн байнгын болон байнгын бус гишүүн нь Биржийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журам, гишүүнчлэлийн гэрээний заалтыг зөрчсөн тохиолдолд арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлэх, цуцлах хүртэл арга хэмжээ авч ажилладаг.

ГУРАВ. ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн хэрэгжилтэд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үр дагаврын үнэлгээ хийлээ.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний үр дүнд үндэслэн Биржийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, цаашид уг хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай гэж үзэн дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

1. Биржийн тухай хуулийн зохицуулалт нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг биржээр арилжаалах, хөрөнгийн зах зээлийн харилцааны зохицуулалтын талаарх дутагдалтай байгаа эрх зүйн орчинг бүрдүүлэх бус зөвхөн бирж, биржийн харилцаанд оролцогч, Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаанд чиглэсэн хууль болсон байна.
2. Биржийн тухай хуулийн зорилтод тодорхойлсон хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, хадгалах, тээвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт хангалтгүй тусгагдсанаас уг хуулийн хэрэгжилт хуульд заасан зорилт, үзэл баримтлалаар дэвшүүлсэн зорилгодоо хүрээгүй байна.
3. Биржийн тухай хуулиар зохицуулж буй харилцаа нь нэг хуулийн этгээдэд илүү төвлөрсөн буюу биржийг үүсгэн байгуулах, түүний зохион байгуулалттай холбоотой зохицуулалтууд голчлон тусгагдсанаас улбаалан хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн арилжаа нь одоог хүртэл бүрэн хөгжөөгүй байна. Өөрөөр хэлбэл, биржийн гол үйл ажиллагаа нь зах зээлийн голлох дэд бүтцийн нэг арилжааг олон улсын жишгийн дагуу зохион байгуулж чадахгүй байна.
4. Зах зээлээс хол хөдөө, орон нутгийн малчид, хоршоодын бараа, түүхий эдийг худалдан авагч тал буюу үйлдвэрлэгч, хэрэглэгчтэй холбосон бодит арилжаа хийгддэггүй, мэдээллийн хүртээмж бага зэргээс шалтгаалан хязгаарлагдмал хүрээнд “бодит бус” арилжаа хийгддэгээс арилжааны мэдээлэл ил тод, нээлттэй байх гэсэн зарчим бүрэн хангагдаагүй.
5. “Биржээр арилжих барааны жагсаалт, код, коджуулах журам”-д заасан түүхий эдийн нэр төрөл, барааны жагсаалтыг зах зээлийн өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан тухай бүр шинэчлээгүйгээс түүхий эд нийлүүлэгчдийн хувьд маргаантай, тодорхойгүй байдлыг үүсгэсэн.

Өөрөөр хэлбэл, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/35 дугаар тушаалаар Үйлдвэрийн бүтээгдэхүүн болох угаасан, самнасан ноолуурыг хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдэд хамааруулснаараа бэлтгэн нийлүүлэгч, малчид бэлтгэсэн түүхий эдээ “олон шат дамжлагагүйгээр хэрэглэгчид байнга, шууд нийлүүлэх боломжтой болно” гэсэн хуулийн үзэл баримтлалд тусгагдсан нийгэм, эдийн засгийн үр дагаврыг бий болгоход чиглэгдээгүй байна.

Түүнчлэн биржээр арилжаалах бүтээгдэхүүний жагсаалтад үйлдвэрийн бүтээгдэхүүнийг оруулсан нь боловсруулах үйлдвэрийн гаралтай бараа, түүхий эдийг арилжаалах давуу

эрх олгосон, улмаар оролцогч талуудын хооронд ойлголтын зөрүү, маргаан үүсгэх нөхцөлийг бий болгосон, малчид, малчдын хоршоод түүхий эдээ бирж дээр гаргаж арилжаанд оролцуулах боломжийг хязгаарлах байдлыг үүсгэсэн байна.

6. Хууль батлагдсанаас хойш хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг биржээр арилжаалсан тохиолдолд урамшуулал олгохтой холбоотой журам батлаагүй бөгөөд харин үндэсний боловсруулах үйлдвэрт ноос, сүү, арьс шир бэлтгэн тушаасан малчдад мөнгөн урамшуулал олгох журмын зохицуулалтаар урамшуулал олгох тогтолцоо үйлчилж байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байх шалтгаан нөхцөлийн нэг болсон.
7. Биржийн тухай хуульд хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршоо, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид биржийн арилжаанд оролцох хуулийн зохицуулалт байхгүйгээс хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийг биржээр арилжсан тохиолдолд урамшуулал олгохтой холбоотой заалт хэрэгжээгүй бөгөөд тус хуулийн зохицуулалт хоорондоо агуулгын хувьд зөрчилтэй, тодорхойгүй байдлыг бий болгох үндэс болсон.
8. Биржийн арилжаанд оролцогчийн хүсэлтээр бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг хянан баталгаажуулах хүрээнд биржийн арилжааны гэрээнд үнэ, чанар, тоо хэмжээ, хүргэлтийн байршил зэрэг үзүүлэлтүүд тусгагдсан ч чанарын баталгаажуулалт хийгддэггүй, баталгаажуулалт хийх техникийн болон бусад шаардлагатай нөхцөл бүрдээгүй, эрх зүйн нарийвчилсан зохицуулалт дутмаг байгаа нь хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна. Тухайлбал, Биржийн барааны шинжээч бараа, түүхий эдийн чанар, тоо хэмжээг нүдэн баримжаагаар тогтоодог, зөвхөн байгаа эсэхийг л харж хяналт тавьж байгаа нь бараа, түүхий эдийн чанарыг лабораторын дүгнэлтээр хянан баталгаажуулах талаар нарийвчилсан эрх зүйн зохицуулалт үгүйлэгдэж байгааг харуулж байна.
9. Биржийн арилжааны зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах зорилготой орон тооны бус биржийн Зохицуулах зөвлөл нь биржийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу чиг үүргээ хэрэгжүүлдэггүй, биржийн үйл ажиллагааг зохистой хөгжүүлэх чиглэлээр өнөөг хүртэл тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй.

Өөрөөр хэлбэл, Зохицуулах зөвлөл нь төрийн бодлого болон хуулийн хэрэгжилтийг хангах, цаг үеийн тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэх, биржийн үйл ажиллагаанд оролцогч төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, арилжаанд оролцогчдын үйл ажиллагааг уялдуулах, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, биржийн үйл ажиллагааг зохицуулах, биржийн бодлогыг тодорхойлох, дүрэм, журам, стандартыг батлах зэрэг чиг үүрэгтэй боловч сүүлийн 5 жилийн хугацаанд 4 удаа хуралдаж, 2015-2016 онд 3 удаа л зөвлөмж гаргасан нь хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж хуулийн зорилгыг хангахад дэмжлэг үзүүлж ажиллаагүйг харуулж байна.

10. Биржийн санхүүгийн болон үйл ажиллагаанд тавих хяналт сул, хэлбэр төдий, дүгнэлт, зөвлөмжийг эрх бүхий байгууллагад тайлагнах тогтолцоо бүрдэж чадаагүй, хяналт тавих эрх бүхий байгууллага хуулиар олгосон чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс хуулийн хэрэгжилт хангалтгүй байх нөхцөл бүрдсэн.
11. Биржийн арилжаанд цахим сүлжээг ашигласнаар цаг хугацаа болон хүн хүч, зардал зэрэг бодит нөөцийг хэмнэхээс гадна хүний хүчин зүйлийн субъектив нөлөөллийг багасгах боломжийг бий болгосон.

12. Хөдөө аж ахуйн биржээр арилжаалсан бараа, түүхий эдийн тодорхойлолтын үйлчилгээний хөлс нь бизнес эрхлэгч, үйлдвэрлэгч нарт дарамт үүсгэж, экспортыг дэмжихэд чиглээгүй байна.
13. Гаалийн тухай хууль болон Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль хоорондын зөрчлөөс шалтгаалан биржээр арилжаалагдсан бараа, түүхий эдийн тоо, экспортод гаргасан бараа, түүхий эдийн тоо хоёр зөрүүтэй гарч байгаа тул хууль хоорондын уялдааг хангах шаардлагатай.
14. Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан бараа нь хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржээр арилжих бараа бол түүний гарал үүслийг биржийн тодорхойлолтыг үндэслэн гэрчилнэ” гэж заасан боловч гарал үүслийн бичгийг биржийн тодорхойлолтыг үндэслэхгүйгээр мөн хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээнд танхимын тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэж заасныг үндэслэн шууд олгож байна.

Ийнхүү Худалдаа, аж үйлдвэрийн танхим нь гарал үүслийн бичгийг олгоходоо биржийн тодорхойлолтыг үндэслэхгүй олгож байгаа нь эрх бүхий байгууллагуудын уялдаа холбоогүй байдал нь хуулийн тус зохицуулалтын эрх зүйн хүчин чадлыг дордуулах, хууль хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд хүргэж байна. Үүний улмаас биржээр арилжаагүй бараа, түүхий эд экспортод гарах, биржийн тодорхойлолт шаардахгүйгээр гаалийн бүрдүүлэлт хийх нөхцөл бүрдсэн байна.

15. Биржийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7-д “энэ хуулийн 4.5-д заасан жагсаалтад орсноос бусад нэр төрлийн бараа, түүхий эдийг биржээр арилжих жагсаалтыг батлах” гэж заасан. Биржийн тухай хуульд заасны дагуу салбарын сайдын баталсан жагсаалтад ороогүй бараа, түүхий эдийг биржээр арилжихтай холбоотой Удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захирлын шийдвэр гараагүй, энэ төрлийн арилжаа хийгдээгүй байна. Түүнчлэн дээр дурдсан бараа, түүхий эдийн жагсаалтыг ямар шалгуураар хооронд нь зааглах асуудал тодорхойгүй, жагсаалт батлах эрх бүхий этгээдийн эрх хэмжээний хүрээ хязгаар, зааг ялгаа зохицуулалтгүй орхигдсон байна.
16. Цаашид биржийн тухай хуулийг арилжаа, арилжааны үйл явц, төлбөр тооцоо, арилжаанд оролцогчид, зуучлагч, бусад мэргэжлийн байгууллага, хөрөнгө оруулагч, бэлтгэн нийлүүлэгч, хадгалалт, хамгаалалт болон бирж дээр арилжаалах үүсмэл гэрээ, тэдгээр нь үнэт цаасанд хамаарах эсэх талаар, үүсмэл гэрээний стандарт, тэдгээрийг арилжаалахтай холбоотой зохицуулалт зэргийг тодорхой тусгаж, арилжаа явуулах зах зээлдээ чиглэсэн харилцааг нарийн зохицуулсан, санхүүгийн зах зээлийн бүтээгдэхүүн бий болгоход чиглэсэн эдийн засгийн агуулгаар өөрчлөх шаардлагатай.
17. Бирж нь хоршоодыг дэмжих, тэдгээрийн үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсээр ирсэн ч “жинхэнэ утгаар” нь ажиллаж, бодит үйл ажиллагаа явуулж байгаа малчдын хоршоо цөөхөн байна. Хоршоо дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр шимийг малчдын хоршоод хүртэж чадахгүй, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжсэн оновчтой, бодитой дэмжлэг болж чадахгүй байгаагаас шалтгаалан хоршоодын тоо төдийлөн нэмэгдэхгүй байна.

Орон нутгийн түүхий эд бэлтгэн нийлүүлэлтэд хоршооны оролцоог нэмэгдүүлэх, малчид хоршоологчдод чиглэсэн сургалт, танин мэдэхүйн ажил дутагдалтай байна. Бараа, түүхий эдийн нөөцийн дийлэнх хэсгийг биржээр дамжуулан үйлдвэрүүд болон гадаад зах зээлд арилжих нөхцөлийг бүрдүүлж, биржийн арилжаанд малчид, тариаланчид хөдөө, орон нутгаас шууд оролцох боломжийг бүрдүүлэх нь чухал байна. Биржийн арилжааны зах

*Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн хэрэгжилтийн
үр дагаврын үнэлгээний тайлан*

зээлийн харилцаанд оролцогчдын тэр дундаа малчид тариаланчид, хоршоологчдын хөдөө аж ахуйн биржийн талаарх ерөнхий ойлголт, улс орон болон эдийн засагт үзүүлэх эерэг үр нөлөө, боломжийн талаарх мэдлэг бага, тэдэнд чиглэсэн сургалт, таниулах ажил хангалттай хийгдэхгүй байгаагаас шалтгаалан биржийн арилжаанд оролцогч хоршоодын тоо нэмэгдэхгүй байна.

---oOo---